



2023

ТОГТВОРТОЙ ХӨГЖЛИЙН
ТАЙЛАН





Тайлан бэлтгэсэнтэй холбоотой мэдэгдэл

Голомт банк ХК-ийн 2023 оны Тогтвортой хөгжлийн тайлан (цаашид “Тайлан” гэх) нь Голомт банк ХК (цаашид “Голомт банк”, “банк” эсвэл “бид” гэх)-ийн Байгаль орчин, Нийгэм, Засаглал (цаашид БОНЗ гэх) болон ногоон санхүүжилтийн чиглэлээр 2023 онд хийгдсэн үйл явц, ахиц дэвшлийн талаар мэдээлэл өгөх зорилготой юм. Үүнд банкны ногоон болон нүүрстөрөгч багатай санаачилгуудыг дэмжсэн болон ногоон санхүүжилтийг уриалсан ололт амжилтуудыг багтаасан болно. Өөрөөр заагаагүй бол, энэхүү тайлан нь 2023 оны 1-р сарын 1-нээс 12-р сарын 31-нийг хүртэлх санхүүгийн жилийн мэдээллийг агуулна.

Тайлангийн тухай

Энэхүү Тогтвортой байдлын тайлан нь Гүйцэтгэх захирлаар баталгаажсан ба дараах хууль дүрэм, стандарт, удирдамжийн дагуу бэлтгэгдсэн болно.

Монголын хөрөнгийн бирж- БОНЗ, Тогтвортой байдлын тайлагналын удирдамж (2022 онд гарсан)

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Санхүүгийн санаачилга-Хариуцлагатай банкны зарчмууд, (2019 онд гарсан)

Монгол Улсын Тогтвортой санхүүжилтийн зарчмууд (2015 онд гарсан)

Санхүүгийн Тогтвортой байдлын зөвлөл/ISSB-ийн Уур амьсгалтай холбоотой санхүүгийн тодруулга хийх ажлын хэсгийн (TCFD) зөвлөмжүүд (2023 онд гарсан)

Өгөгдлийн мэдэгдэл

Тайлан дахь тоо баримтууд нь 2023 оны 1-р сарын 1-нээс 2023 оны 12-р сарын 31-ний хооронд байна. Өөрөөр заагаагүй бол тайланд дурдсан мөнгөн дүн төгрөгөөр илэрхийлэгдсэн болно.

Нийтлэлийн хэлбэр

Тайланг онлайн хэлбэрээр банкны вэбсайтаас татан авах боломжтой. Тайлан нь англи, монгол хэл дээр гарсан бөгөөд хоёр хувилбарын хооронд зөрүү гарсан тохиолдолд монгол хувилбарыг баримтална.

АГУУЛГА

Гүйцэтгэх захирлын мэндчилгээ	6
Тогтвортой байдлын онцлох мэдээллүүд	8
Тогтвортой байдлын он цагийн товчоо	10
Тогтвортой байдлын стратеги	14
Стратеги зорилго 1: Тогтвортой засаглал	16
Төлөөлөн удирдах зөвлөл	18
Тогтвортой хөгжлийн хорооны тухай	19
Жендэрийн тэгш байдлын хорооны тухай	19
Тогтвортой санхүүжилтийн хэлтсийн тухай	19
Стратеги зорилго 2: Тогтвортой, ногоон санхүүжилт	20
Бизнесийн багц	21
Санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарал	22
Хүлэмжийн хийн ялгарал өндөр салбарууд	25
Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах шилжилтийг санхүүжүүлэх нь	26
Тогтвортой, ногоон зээлийн багц	27
Тэгш, хүртээмжтэй шилжилтийг санхүүжүүлэх нь	28
Эрчим хүчний салбар дахь тогтвортой шилжилт	28
Уул уурхайн салбар дахь тогтвортой шилжилт	28





БОНЗ-ын мэдлэгийг цогцлоох нь	29
Иргэдийн багц	30
Санхүүгийн хүртээмж	30
Санхүүгийн хүртээмж бага нийгмийн бүлэгт хүрч ажиллах	31
Дижитал шилжилт	32
Жижиг дунд бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг бэхжүүлэх	33
Банкны өдөр тутмын үйл ажиллагааг тогтвортой, ногоон болгох	34
Байгаль орчин	35
Мэдлэгээ хуваалцах, бусдыгаа манлайлах нь	37
Нийгэм	41
Шилдэг байгууллагын соёлыг бүрдүүлэх нь	41
Ажилтнуудын сургалт, хөгжил	41
Олон талт, тэгш, хүртээмжтэй байдлыг хангах нь	42
Стратеги зорилго 3: Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн удирдлага	44
Харилцагчдын БОНЗ-ын эрсдэлийг удирдах нь	47
Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл ба боломжууд	47
Стратеги зорилго 4: Олон талт оролцоо	48
Олон талт оролцооны зураглал	49
Олон талт оролцоо	50
Аргачлал	51



Тоон тодруулга	52
Ажилтнуудын тоон мэдээлэл	53
Эгнээндээ нэгтгэсэн шинэ ажилтнууд/дадлагажигч	54
Байгаль орчинтой холбоотой тоон мэдээлэл	54
Бусад мэдээлэл	57
Ажилтнуудад зориулсан сургалт	57
Ажилтнуудад зориулсан тэтгэмж	57
Санхүүгийн хүртээмж – Дижитал шилжилт	58
Кибер аюулгүй байдал	58
Олон талт оролцоо	58
“Тэрбум Мод” Сан	59
Харилцагчидтай холбоотой тоон мэдээлэл	59
БОНЗ-тай холбоотой бодлого, журмууд	60
БОНЗ тайлагналын стандартуудын нийцэл	61
НҮББОХ-Банк Санхүүгийн Санаачилга, Хариуцлагатай банкны зарчмууд	61
Монголын хөрөнгийн биржийн БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын стандарт	62
БОНЗ-той холбоотой шагнал, үнэлгээ	64
Ил тод нээлттэй тайлагнал	64





ГҮЙЦЭТГЭХ ЗАХИРЛЫН МЭНДЧИЛГЭЭ



Бид байгаль орчин болон нийгэмд тулгарч буй сорилтуудыг сааруулах, дасан зохицох, даван туулахад шаардагдах ногоон эдийн засгийн шилжилтийг эрчимжүүлэх, холбогдох инновацийг дэмжих замаар харилцагчидтайгаа хамтран тогтвортой, урт хугацааны эдийн засгийн өсөлтийг бий болгохоор зорин ажиллаж байна.

Голомт банкны хувьд харилцагчид, хөрөнгө оруулагчид, зохицуулагч байгууллагуудын хүсэлт, шаардлагатай нийцсэн, мөн банкны эрсдэлийн аппетитад тохирсон тогтвортой байдлын урт хугацааны зорилтыг тэргүүлэх чиглэлээ болгон ажилладаг. Бидний тогтвортой хөгжлийн хөдөлгөгч хүч нь ажилтан бүрийн идэвх санаачилга хичээл зүтгэл, бүтээлч сэтгэлгээ билээ.

Бид ч бас энэхүү тогтвортой, ногоон шилжилтийг хийх аялалдаа гарсан ба үүний хүрээнд өөрсдийн үйл ажиллагаа, ханган нийлүүлэлтийн сүлжээ, санхүүжилтийн үйл ажиллагаандаа 1.5C хэмийн дагуу ногоон, тогтвортой эдийн засгийн шилжилт хийх зорилго тавин ажиллаж байна. Үүний хүрээнд, 2030 он хүртэлх дунд хугацааны болон 2050 он хүртэлх урт хугацааны зорилтуудаа батлан ажиллаж байна.

Тогтвортой хөгжлийн тайлангаараа дамжуулан бид ил тод мэдээлэх, хувьсан өөрчлөгдөж буй БОНЗ-ын зах зээлийн жишгийг хэрэгжүүлэх үүргээ биелүүлж байгаа бөгөөд энэхүү тайлан нь оролцогч талуудад бидний үйл ажиллагааны явцыг ойлгох, хянах, харьцуулах боломжийг олгож байна.



Тогтвортой байдал нь олон боломжууд, эерэг нөлөөллийг бий болгож байгаа хэдий ч мөн олон эргэлзээг дагуулж байдаг. Бидний хувьд 2023 он уур амьсгалын өөрчлөлтийг сааруулах, дасан зохицохтой холбоотой амлалтууд, хийж хэрэгжүүлсэн ажлуудаа хэмжиж болохуйц, хэрэгжүүлэх боломжтой стратеги, шийдэл болгон хувиргах эргэлтийн цэг байсан ба ногоон, тогтвортой эдийн засгийн шилжилтийг хийх үйл явцад дэмжлэг үзүүлэх үүргээ хэрэгжүүлсээр байна.

Тогтвортой байдлын стратеги болон амлалтын хүрээнд бид байгаль орчин, нийгэм, эдийн засгийн өсөлтөд үзүүлж буй эерэг нөлөөллийг хэмжих - өөрийн үйл ажиллагаа болон санхүүжилтээр дамжуулан ялгаруулж буй хүлэмжийн хийн тооцооллыг хийх, 2030 он хүртэлх

дунд болон 2050 он хүртэлх урт хугацааны зорилтуудаа эцэслэн баталж, амлалтаа ажил хэрэг болгоход анхааран ажиллаж байна. Цаашид хийх зүйл их байгаа нь ойлгомжтой хэдий ч жилээс жилд ахиц дэвшил гарч байгаа нь сайшаалтай бас чухал юм.

Энэ жилийн Тогтвортой хөгжлийн тайлантай танилцахад таатай байх болно гэдэгт итгэлтэй байна. Голомт банк нь тогтвортой байдлын стратегиа үргэлжлүүлэн хэрэгжүүлж, сайжруулж, бодит эерэг нөлөөллийг бий болгосоор байх болно. Энэхүү аялалд бидэнтэй хамтран ажиллаж буй эрхэм ажилтнууд, харилцагчид, зохицуулагч байгууллагууд, олон улсын хөгжлийн байгууллагууд болон бусад оролцогч талуудаа талархал илэрхийлье!

Хүндэтгэсэн,

Гүйцэтгэх захирал
Норихико Като



ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫН ОНЦЛОХ
МЭДЭЭЛЛҮҮД





Тогтвортой байдлын онцлох мэдээллүүд

565 ТЭРБУМ

2019 оны 3-р улирлаас 2023 оны 4-р улирлын хооронд 565 тэрбум төгрөгийн тогтвортой, ногоон санхүүжилтийг олгосон бөгөөд үүнээс 243 тэрбум төгрөгийг 2023 онд олгосон байна.

2030: 30% (суурь өгөгдөл 2023)

2050: 50% (суурь өгөгдөл 2023)

Уур амьсгалд үзүүлэх сөрөг нөлөөллийг бууруулах дунд болон урт хугацааны зорилтуудаа эцэслэн батлав. (Өөрийн үйл ажиллагаа болон санхүүжүүлсэн зээлийн багц)

2,710,672 тн CO2e

Өөрийн үйл ажиллагаанаас ялгарч буй хүлэмжийн хийн хэмжээг тооцоолов.

183 ТЭРБУМ

Ногоон зээлийн багц 183 тэрбум төгрөг болсон байна. Энэ нь:
Банкны нийт зээлийн багцийн 3.8%
Зах зээлийн 23%

2030: 5% (суурь өгөгдөл 2023)

2050: 10% (суурь өгөгдөл 2023)

Усны менежментийг сайжруулах дунд болон урт хугацааны зорилтуудаа эцэслэн батлав. (Өөрийн үйл ажиллагаа болон санхүүжүүлсэн зээлийн багц)

1,607,027 тн CO2e

Санхүүжүүлсэн хүлэмжийн хийн хэмжээг тооцоолов.

Бүх ажилтнуудад зориулсан дараах сургалтуудыг Банкны сургалтын хөтөлбөрт оруулав.

- **Хүний эрх**
- **Хүйсийн тэгш байдал**



Тогтвортой байдлын он цагийн товчоо



- “Тогтвортой Санхүүжилтийн Бодлого”-ыг батлав.
- 50 сая төгрөгөөс дээш дүнтэй зээл бүрд Байгаль орчин, нийгэм эрсдэлийн үнэлгээ хийж эхлэв.

2015-2016 ▶



- “Жендэрийн Тэгш Байдлыг Хангах Бодлого”-ыг батлав.
- Олон Улсын Санхүүгийн Корпорацийн “Ногоон Санхүүжилтийн Чадавх Бэхжүүлэх Хөтөлбөр”-т хамрагдав.
- НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөр, Санхүүгийн Санаачилга “Хариуцлагатай Банкны Зарчмууд”-ыг үүсгэн байгуулах ажлын хэсэгт нэгдэв.



2018 ▶



2017 ▶

- ToC “Манлай Банк”-аар шалгарав.



2019 ▶

- “Тогтвортой санхүүжилтийн бодлого”-ыг шинэчлэн “Тогтвортой хөгжлийн бодлого” болгон өргөжүүлж, батлав.
- Монголбанкнаас баталсан “МУ-ын Ногоон Таксономи” буюу байгаль орчин, нийгэмд ээлтэй ногоон төсөл, бизнесүүдийг таних Банкнуудын нийтлэг ашиглах баримт бичгийн дагуу ногоон төсөл, бизнесийг таньж, ангилж эхлэв.
- Монголбанк руу ногоон зээлийн багцаа тайлагнаж эхлэв.
- “Хариуцлагатай Банкны Зарчмууд”-д албан ёсоор нэгдэв.
- НҮБ-ын “Уур Амьсгалын Өөрчлөлтийн Эсрэг Хамтын Амлалт” ажлын хэсэгт нэгдэв.





- Байгаль орчин, нийгэм эрсдэлийн үнэлгээг сайжруулав.
- Ажилтнуудад тогтвортой хөгжлийн чадавх сайжруулах сургалт, хөтөлбөрүүд хэрэгжүүлж эхлэв.
- Тогтвортой хөгжлийн жилийн тайлан гаргаж эхлэв.
- “Онцлох ТоС Банк 2020”-оор шалгарав.

2020 ▶



2021 ▶

- Банкны зээлийн багцаас Байгаль орчин, нийгэмд үзүүлэх нөлөөллийн шинжилгээг НҮБ-ын Байгаль Орчны Хөтөлбөр, Санхүүгийн Санаачилгын хөгжүүлсэн хэрэгслийг ашиглан хийв.
- Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих бүтээгдэхүүн гаргав.
- Хариуцлагатай банкны жилийн тайлан гаргаж эхлэв.
- ТоС “Манлай Банк 2021” дахин шалгарав.



- Тогтвортой, ногоон зээлийн бүтээгдэхүүн гаргаж эхлэв.
- Байгаль орчин, нийгэм эрсдэлийн үнэлгээний дотоод процессыг сайжруулав.
- “Онцлох ТоС байгууллага 2022”-оор шалгарав.
- Хүлэмжийн хийн тооцоолол, санхүүгийн бүртгэлийн түншлэл (PCAF)-д нэгдэв.
- Санхүүжүүлсэн CO2 тооцож эхлэв.
- ТоС “Жендэрийн манлай байгууллага 2023”-аар шалгарав.
- Уур амьсгалын болон усны зорилтоо тодорхойлов.



2022-2023 ▶





Уур амьсгалын өөрчлөлт нь харилцагчид болон банкны хувьд томоохон эрсдэл болон боломжуудыг бий болгож байна. Хүлэмжийн хийн ялгаруулалтыг дэлхийн хэмжээнд мэдэгдэхүйц бууруулахын тулд зах зээлийн гол салбаруудад томоохон хэмжээний хөрөнгө оруулалт шаардлагатай болоод байгаа билээ. Энэ нь Голомт банканд болон харилцагчдад ногоон, тогтвортой эдийн засгийн шилжилт хийх хэрэгцээ болон боломж байгааг илтгэж байна. Иймээс бид уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг сааруулах, дасан зохицоход чухал үүрэг, хариуцлага хүлээн ажиллаж байна.

Голомт банкны хувьд, санхүүжилтийн болон хөрөнгө оруулалтын үйл ажиллагаагаа Парисын хэлэлцээрийн зорилгуудтай уялдуулан дэлхийн дулаарлыг аж үйлдвэржилтийн өмнөх үетэй харьцуулахад 2 хэмээс хэтрүүлэхгүй байж, улмаар 1.5 хэмд хязгаарлах зорилттой нийцүүлэх хэмээн харж байна. Иймд Монгол Улсын шилжилтийн төлөвлөгөөг харгалзан үзэж бид 2050 он гэхэд нийт зээлийн багц, өөрийн үйл ажиллагаанаас ялгаруулж буй хүлэмжийн хийн хэмжээг 50 хувь бууруулах зорилт тавиад байна.

Бид 2030 он гэхэд өөрийн үйл ажиллагаанаас үүдэх хүлэмжийн хийн ялгаруулалт буюу хамрах хүрээ 1, 2 болон 3-ыг хамарсан дунд хугацааны зорилтыг тавин ажиллаж байна.





ТОГТВОРТОЙ
БАЙДЛЫН СТРАТЕГИ



Бидний тогтвортой байдлын стратеги

Голомт банк нь тогтвортой хөгжлийн үзэл баримтлалыг бизнесийн стратегид бүрэн тусгаж, Үндэсний тодорхойлсон хувь нэмэр, баримт бичиг болон Парисын хэлэлцээрийн хэрэгжилтийг хангахад хувь нэмрээ оруулан, ногоон санхүүгийн хүчирхэг тогтолцоог бүрдүүлэхийн төлөө бүхий л хүчин чармайлтаа гарган ажиллаж байна.



СТРАТЕГИ ЗОРИЛГО 1 Тогтвортой засаглал

Өөрийн болон харилцагчдын ногоон, тогтвортой эдийн засгийн шилжилтийг хийх зорилго, төлөвлөгөөг хэрэгжүүлэх, дэмжих



СТРАТЕГИ ЗОРИЛГО 3 Уур амьсгалын эрсдэлийн удирдлага

Уур амьсгалын өөрчлөлтөөс үүдэн гарах эрсдэлийг удирдах



СТРАТЕГИ ЗОРИЛГО 2 Тогтвортой, ногоон санхүүжилт

Тогтвортой, ногоон санхүүжилтийн хүрээг тэлэх



СТРАТЕГИ ЗОРИЛГО 4 Олон талт оролцоог хангах

Зорилго, зорилтуудаа хэрэгжүүлэхэд оролцогч талуудтай хамтын ажиллагааг бэхжүүлэх



СТРАТЕГИ ЗОРИЛГО 1:
ТОГТВОРТОЙ
ЗАСАГЛАЛ



Стратеги зорилго 1: Тогтвортой засаглал

Голомт банк нь тогтвортой байдал, ногоон санхүүжилтийн чиглэлээрх оролцоог Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) болон удирдлагын багийн үүрэгт бүрэн тусган ажиллаж байна. Үүний хүрээнд, ТУЗ, удирдлагын баг, мэргэшсэн багаас бүрдсэн гурван шатлалт засаглалын бүтцийг хэвээр хадгалж, тогтвортой байдал, ногоон санхүүжилтийн засаглалын стандартыг сайжруулсаар байна. Ингэснээр банкны тогтвортой байдлын стратегийн хэрэгжилттэй холбоотой ажлыг урагшлуулах бат бөх суурийг тавьсан байна.



Төлөөлөн удирдах зөвлөл

Төлөөлөн удирдах зөвлөл (ТУЗ) нь банкны бүхий л стратегийн чиглэл, удирдлага, хяналтыг хариуцдаг. ТУЗ нь Аудитын хороо, Эрсдэлийн удирдлагын хороо, Засаглал, Ёс зүй, Цалин урамшууллын хороо, Нэр дэвшүүлэх хороо гэсэн дөрвөн байнгын хороотой. 2023 оны 12-р сарын 31-ний байдлаар ТУЗ нь нийт 5 хараат, 3 хараат бус гишүүнтэй ажилласан байна.

ТУЗ-ийн гишүүдийн туршлага болон мэргэшил Манлайллын туршлага

Санхүүгийн салбар дахь гүйцэтгэх удирдлагын туршлага (>10 жил)	■	■	■	■	■				
Хөрөнгийн биржид бүртгэлтэй компанийн ТУЗ-ийн хараат бус гишүүн	■	■	■						



Мэргэшлийн чиглэлүүд

Хөрөнгө оруулалтын менежмент	■	■	■						
Санхүү / аудит	■	■	■	■	■	■			
Эрсдэл, хууль эрх зүй / нийцэл	■	■	■						
Хүний нөөц, компанийн соёл	■	■							
Дижиталчлал / технологи	■								
БОНЗ	■								
Засгийн газар, зохицуулалтын байгууллага / академи	■	■							

Тогтвортой хөгжлийн хорооны тухай

Голомт банк нь 2022 онд Удирдлагын хорооны 2021 оны 11-р сарын 17-ны өдрийн 27 дугаар тушаалаар Тогтвортой хөгжлийн хороог байгуулсан бөгөөд тус хороо нь банкны тогтвортой санхүүжилт, тогтвортой хөгжлийн стратегийн хэрэгжилтэд хяналт тавьж, удирдан зохион байгуулах үүргийг гүйцэтгэж байна. Тогтвортой байдлын дотоод болон гадаад төлөвлөгөө, хэрэгжилтийг хэлэлцэх зорилгоор жилд дор хаяж хоёр удаа хуралддаг. Гүйцэтгэх захирал хороог даргалдаг бол Тогтвортой санхүүжилтийн хэлтэс нь нарийн бичгийн даргын албыг гүйцэтгэдэг.

Жендэрийн тэгш байдлын хорооны тухай

Жендэрийн тэгш байдлын хороо нь 2021 онд байгуулагдсан бөгөөд банкны бүтээгдэхүүн үйлчилгээ болон банкны өдөр тутмын үйл ажиллагаанд жендэрийн эрх тэгш байдлын хэрэгжилтийг хангах зорилготой юм. Хороо нь удирдлагын багийн гишүүдээс бүрдэх ба гүйцэтгэх захирал тэргүүлдэг.

Тогтвортой санхүүжилтийн хэлтсийн тухай

Удирдлагын хорооны 2021 оны 12-р сарын 21-ний өдрийн 21/03 тоот тушаалаар Тогтвортой санхүүжилтийн хэлтэс албан ёсоор байгуулагдсан. Тус хэлтэс нь банкны тогтвортой хөгжлийн бодлого болон холбогдох стратегийн хэрэгжилтийг хангах, чиглүүлэх, олон улсын болон үндэсний стандартад нийцүүлэх, харилцагчдын БОН-ийн эрсдэлийг үнэлэх, ногоон болон тогтвортой санхүүжилтийг тодорхойлох, баталгаажуулах, үндэсний болон олон улсад мөрдөгдөж буй тайлагнах стандартыг хэрэгжүүлэх чиг үүргийг хүлээн ажиллаж байна.

Гүйцэтгэх захиралтай зөвшилцсөний үндсэн дээр Тогтвортой санхүүжилтийн хэлтэс нь тогтвортой байдалтай холбоотой КРІ-ийг тодорхойлж, зорилтуудыг тавин, тодорхойлсон КРІ-ийн гүйцэтгэлд чиглэл өгөн оролцдог. Уг ажлыг 2023 оны 2-р хагас жилээс эхлүүлсэн бөгөөд жил бүр өргөжүүлэн сайжруулсаар байна.



СТРАТЕГИ ЗОРИЛГО 2:
ТОГТВОРТОЙ, НОГООН
САНХҮҮЖИЛТ




Бизнесийн багц

Олон улсын жишгээр банк, санхүүгийн байгууллагуудын хувьд санхүүжилтээр дамжуулан уур амьсгалын өөрчлөлтөд үзүүлж буй нөлөөлөл нь өндөр байдаг билээ. Тиймээс, бид тогтвортой, хүртээмжтэй өсөлт, хөгжил цэцэглэлтэд хувь нэмэр оруулахын зэрэгцээ харилцагчдын ногоон, тогтвортой шилжилтийг дэмжих чадавхаа тасралтгүй бэхжүүлж байх нь чухал болоод байна. Энэ хэсэгт бид байгууллагууд, жижиг дунд бизнес эрхлэгчид болон иргэдэд олгосон санхүүжилт нь хэрхэн байгаль орчин, нийгэм, эдийн засагт нөлөөлж буй талаарх дүн шинжилгээний үр дүнг нэгтгэн танилцуулж байна.

НҮББОХ-ийн Банк Санхүүгийн Санаачилга - Хариуцлагатай банкны зарчмууд нь Тогтвортой хөгжлийн зорилгууд болон Парисын хэлэлцээрийн зорилгуудтай нийцүүлэн тогтвортой ногоон эдийн засгийн хөгжилд хувь нэмрээ оруулах, бэхжүүлэх үндсэн суурь юм. Энэхүү Санаачилгын хүрээнд Голомт банк нь 2021 оноос эхлэн жил бүр зээлийн багцын байгаль орчин, нийгэмд үзүүлж буй эерэг ба сөрөг нөлөөллийн дүн шинжилгээг хийж, сөрөг нөлөөлөл өндөр хоёр чиглэл болох хүрээлэн буй орчин болон биологийн олон янз байдал тэр дундаа тогтвортой усны менежмент болон уур амьсгалын өөрчлөлтийн нөлөөллийг онцлон, зорилтуудыг тавин ажиллаж байна. Энэ онд бид зээлийн багцын нөлөөллийн дүн шинжилгээг шинэчлэн хийсэн ба зээлийн багцын бүтцэд материаллаг өөрчлөлт гараагүй тул онцлох чиглэлүүдэд өөрчлөлт ороогүйг баталгаажууллаа.

Багцын нөлөөллийн шинжилгээ






Санхүүжүүлсэн Хүлэмжийн хийн ялгарал


НҮББОХ-ийн Банк Санхүүгийн Санаачилгад нэгдэн, амлалт өгсний дагуу хоёрдугаар зарчим болох Нөлөөлөл ба Зорилтыг тодорхойлж, жил бүр зорилгодоо хүрэх хэрэгжилтийг хянаж, тайлагнах үүрэг хүлээсэн. Энэ хүрээнд бид 2023 оны 12-р сарын 31-ний байдлаарх нийт зээлийн багцын санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлыг амжилттай тооцоод байна.

Хүлэмжийн Хийн Тооцоолол, Санхүүгийн Бүртгэлийн Түншлэл /ХХТСБТ/ буюу PCAF болон Хамтын Нөлөөллийн Сан буюу JIM Foundation-д гишүүнээр элссэнээр банк 2023 оны 12-р сарын 31-ний байдлаар нийт зээлийн багцын санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарал болох 1,607,027 тнCO₂e тооцсон болно. Банкны нийт санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлын 65 хувийг бизнесийн зээлийн багц бүрдүүлж байгаа бөгөөд үүний 55 хувийг нүүрстөрөгч, 45 хувийг бусад хий эзэлж байна.

Санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарал, ХХТСБТ буюу PCAF ангиллаар



Нийт багцын санхүүжүүлсэн ялгаруулалт, хүлэмжийн хийн төрлөөр



Үүнээс гадна зээлийн багцаар дамжуулан нийт 68,267 ажлын байрыг бий болгож 1.8 их наяд төгрөгийн нэмүү өртгийг хадгаламж, татвар болон цалин хэлбэрээр бий болгон ТХЗ-уудад хувь нэмрээ оруулсан байна.

ШИНЭЭР БИЙ БОЛГОСОН АЖЛЫН БАЙРНЫ ТОО



68,267




БИЙ БОЛГОСОН НЭМҮҮ ӨРТӨГ



НИЙТ 534,142,741
АМ ДОЛЛАР БУЮУ
1,8 ИХ НАЯД ТӨГРӨГ


ШИНЭЭР БИЙ БОЛГОСОН АЖЛЫН БАЙР, ХҮЙСЭЭР

/ЭМЭГТЭЙЧҮҮД, ХЭЛБЭРЭЭР/



■ Бизнесийн зээл ■ Орон сууцны зээл
■ Хэрэглээний зээл ■ Автомашины зээл

БИЙ БОЛГОСОН НЭМҮҮ ӨРТӨГ, АНГИЛЛААР



■ Бизнесийн зээл ■ Орон сууцны зээл
■ Хэрэглээний зээл ■ Автомашины зээл

Хүлэмжийн хийн ялгарал өндөр салбарууд


Голомт банк дараах салбаруудыг Хүлэмжийн хийн ялгарал өндөр хэмээн тодорхойлсон байдаг. Үүнд:

- Хөдөө аж ахуй
- Эрчим хүчний хуваарилалт ба дамжуулалт
- Уул уурхай - Нүүрс олборлолт, алт олборлолт, төмрийн хүдэр олборлолт
- Хуурай замын ачаа тээвэр
- Үйлдвэрлэл
- Барилга ба үл хөдлөх

Нэмж дурдахад банк Уур Амьсгалын Өөрчлөлтийн Асуудлаарх Засгийн Газар Хоорондын Зөвлөл буюу IPCC болон Олон Улсын Эрчим Хүчний Агентлаг болох IEA нийтлэн гаргасан WEA 21 салбарын ангилалд нийцүүлэн Барилга ба Үл хөдлөхийн салбарыг нэмж оруулсан юм. Дээрх салбаруудын санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлын хэмжээ 839,838 тнCO₂e байна.



Хүлэмжийн хийн ялгарал өндөр салбарууд



- 10% Уул уурхай
- 0% Эрчим хүч
- 47% Барилга
- 18% Хөдөө аж ахуй
- 23% Үйлдвэрлэл
- 2% Тээвэр

Банк нь ирэх жилүүдэд эдийн засгийн салбар тус бүрд хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах дэд зорилтууд болон хэрэгжилтийн төлөвлөгөөг үе шаттайгаар нэвтрүүлэн ажиллахаар бэлтгэл ажлаа эхлүүлээд байна.

Санхүүжүүлсэн хүлэмжийн хийн тооцоолол, ажлын байр бий болгосон байдал болон эдийн засгийн өсөлтөд хувь нэмрээ оруулж буй тооцооллыг хийсэн аргачлалын дэлгэрэнгүйг Аргачлал хэсгээс харна уу.

Хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах шилжилтийг санхүүжүүлэх нь

Харилцагчид бидний философийг ойлгон дэмжиж хамтдаа хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, илүү тогтвортой, ногоон бизнесийн загваруудыг нутагшуулахын тулд зохих арга хэмжээнүүдийг авсаар байна. Тиймээс бид санал болгож буй бүтээгдэхүүн үйлчилгээ, тэр дундаа санхүүжилтээрээ дамжуулан харилцагчдынхаа тогтвортой байдлыг бэхжүүлэхэд хамтран ажиллаж байгаа билээ.

Уур амьсгалын өөрчлөлт болон банк санхүүгийн байгууллагуудын харилцаа холбоо хоёр байдлаар холбогдож байдаг – уур амьсгалын өөрчлөлт нь зээлийн багцад эрсдэл бий болгож байдаг ч нөгөө талаар банк санхүүгийн байгууллагууд нь олгож буй санхүүжилтээрээ дамжуулан уур амьсгалын өөрчлөлтөд эерэг болон сөрөг нөлөөллийг үзүүлж байдаг. Бид энэхүү хоёр талт харилцаа холбоог уур амьсгалын эрсдэлийн удирдлагын тогтолцоог бэхжүүлж тавьсан зорилтууддаа хүрэх хэрэгжилтийг хангах замаар авч явдаг. Үүний хүрээнд тогтвортой, ногоон бизнесийн санхүүжилтийн бүтээгдэхүүн, үйлчилгээг санал болгох замаар ногоон бизнесийн шилжилтийг хийхэд хамтран шинэ боломжуудыг нээсээр байна.

Голомт банк нь дараах бүтээгдэхүүнүүдийг зах зээлд нэвтрүүлэн харилцагчдадаа санал болгож байна. Үүнд:

	Сарын хүү	Дээд хэмжээ	Хугацаа (сар)
Тогтвортой, ногоон бизнесийн зээл (гадны болон өөрийн эх үүсвэр)	1.2% - 1.4%	5-10 тэрбум төгрөг	30-84
Хүү хуваан төлөх нөхцөлтэй ногоон зээл	1.2% - 1.4%	5-10 тэрбум төгрөг	84
Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээл	1.2% - 1.4%	100 сая төгрөг	36



Тогтвортой, ногоон зээлийн багц

Банк нь 2030 он гэхэд нийт зээлийн багцын 10%-ийг тогтвортой, ногоон зээлийн багцаар бүрдүүлэх зорилгыг тавин ажиллаж байна.

БИЙ БОЛГОСОН АЖЛЫН
БАЙРНЫ ТОО




НИЙТ: 4543
ЭМЭГТЭЙЧҮҮД: 2210

БИЙ БОЛГОСОН
НЭМҮҮ ӨРТӨГ




НИЙТ: 31,823,187 АМ ДОЛЛАР
БҮЮУ 108.5 ТЭРБУМ ТӨГРӨГ

Тогтвортой, ногоон зээлийн багцын төлөвлөгөө



Өнгөрсөн дөрвөн жилийн хугацаанд бид нийт 565 тэрбум төгрөгийн тогтвортой, ногоон санхүүжилтийг олгосон байна. Үүнээс, 2023 онд нийт 243 тэрбум төгрөгийн тогтвортой, ногоон санхүүжилт олгосон ба 2023 оны 12-р сарын 31-ний байдлаарх тогтвортой, ногоон зээлийн багц 183 тэрбум төгрөгийн үлдэгдэлтэй байна. Багцын бүрдлийг харахад эрчим хүчний хэмнэлт, тогтвортой хөдөө аж ахуй, тогтвортой ус, хог хаягдлыг дэмжих санхүүжилт нь 98.93%-ийг бүрдүүлж байгаа ба үүний 71%-ийг байгууллагын банкны харилцагчид, 26%-ийг жижиг дунд бизнес эрхлэгчид, үлдсэн 3%-ийг иргэд эзэлж байна.

Ангилал	2022Q4	2023Q4
Сэргээгдэх эрчим хүч	0.07%	0.00%
Карбон бага ялгаруулдаг тээвэр	1.20%	0.66%
Эрчим хүч хэмнэлт	0.05%	52.41%
Ногоон барилга	57.38%	0.00%
Бохирдол багатай эрчим хүч	0.00%	0.41%
Тогтвортой ХАА	20.87%	41.89%
Тогтвортой ус, хаягдлын хэрэглээ	20.43%	4.62%
Бохирдлоос сэргийлэх, бууруулах ү.а.	0.00%	0.00%



Тэгш, хүртээмжтэй шилжилтийг санхүүжүүлэх нь

Бид өөрсдийн үйл ажиллагаанаас болон санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах зорилго зорилтуудаа тодорхойлон, хэрэгжилтийг ханган ажиллаж байгаа хэдий ч эдийн засгийн өсөлт нь уул уурхайн салбараас ихээхэн хамааралтай, эрчим хүчний гол эх үүсвэр нь нүүрс хэвээр байгаа нөхцөлд тогтвортой, ногоон шилжилтийг богино хугацаанд хийх нь бэрхшээлтэй гэдгийг хүлээн зөвшөөрч байна. Иймд хүрэн салбарын шилжилтийг оролцогч талуудад хүртээмжтэй, тэгш, санхүүгийн үр ашигтай байдлаар бий болгохын тулд хамтын ажиллагаагаа тэлсээр байна.

Эрчим хүчний салбар дахь тогтвортой шилжилт

Сэргээгдэх эрчим хүч, эрчим хүчний салбар дахь оролцогч талуудтай хамтын ажиллагааг өргөжүүлэх

Харилцагчдын эрчим хүчний эх үүсвэрийн, доод тал нь 20%-ийг сэргээгдэх эрчим хүчээр хангах, эрчим хүчний хэмнэлт үүсгэх зөвлөгөө өгөх сургалтыг орох

Харилцагчдын эрчим хүчний эх үүсвэрийн, доод тал нь 20%-ийг сэргээгдэх эрчим хүчээр хангах, эрчим хүчний хэмнэлт үүсгэх бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгох

Банкны эрчим хүчний салбар дахь багцын хэмжээг ил тод, нээлттэй тайлагнах



Уул уурхайн салбар дахь тогтвортой шилжилт

Уул уурхайн салбар дахь оролцогч талуудтай тогтвортой ногоон бизнесийн шилжилт хийх, хамтын ажиллагааг өргөжүүлэх

Харилцагчдад зөвлөгөө өгөх сургалтыг орох

Харилцагчдад тохиромжтой бүтээгдэхүүн, үйлчилгээ санал болгох

Банкны уул уурхайн салбар дахь багцын хэмжээг ил тод, нээлттэй тайлагнах




БОНЗ-ын мэдлэгийг цогцлоох нь

Хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй байгаль орчин, нийгэм, засаглалын салбарт, банкны тогтвортой хөгжлийн бодлого, стратегийг хэрэгжүүлэхэд хамгийн чухал хүчин зүйл нь нийт ажилтнуудын уур амьсгалын өөрчлөлт, тогтвортой хөгжлийн зорилгууд болон тогтвортой санхүүжилтийн талаарх ойлголтын түвшин билээ. Тиймээс БОНЗ-ын чиглэлээрх сургалтуудыг банкны нийт ажилтнуудын заавал хамрагдах сургалтаар батлан, хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Банкны харилцааны болон корпорэйт менежерүүд харилцагчдад тогтвортой, ногоон бизнесийн шилжилтийн талаарх мэдээлэл түгээх чухал үүрэг гүйцэтгэдэг. Иймээс, энэ үүргээ гүйцэтгэхэд цогц мэдлэг, мэдээлэлтэй байх зорилгоор байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээний зохицуулалт, банкны санал болгож буй ногоон, тогтвортой бүтээгдэхүүн, үйлчилгээ, болон салбарын өнөөгийн чиг хандлагын талаарх заавал хамрагдах Тогтвортой санхүүжилтийн цахим сургалтыг үзэх шаардлагыг хэрэгжүүлэн ажиллаж байна. Шинээр ажилд орсон харилцааны болон корпорэйт менежерүүд энэхүү сургалтад хамрагдах шаардлагатай байдаг бол одоо байгаа харилцааны болон корпорэйт менежерүүд жил бүр давтан сургалтад хамрагдах үүрэг хүлээн ажиллаж байна.

Сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо, давхардсан тоогоор



Тогтвортой санхүүжилт

Байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээ

Тогтвортой хөгжлийн бодлого

Жендэрийн тэгш байдал

Хүний эрх ба бизнес



Иргэдийн багц

Голомт банк нь харилцагч төвтэй банкны үйлчилгээ буюу хадгаламж, харилцах, дижитал банк, зээл, картын бүтээгдэхүүн, гадаад төлбөр тооцоо, даатгал зэрэг олон төрлийн бүтээгдэхүүн үйлчилгээг Монгол Улсын өнцөг булан бүрд суугаа нэг сая гаруй харилцагчдаа салбар тооцооны төвүүд болон цахим сувгуудаар хүргэн ажиллаж байна.

Банк нь тогтмол хувьсан өөрчлөгдөж буй харилцагчдын хэрэгцээ, хүлээлтэд нийцүүлэх, тогтвортой амьдралын хэв маягийг бүрдүүлэх зорилготой дижитал шилжилтийг эрчимтэй хийж, илүү хүртээмжтэй, тогтвортой, ногоон бүтээгдэхүүн үйлчилгээг санал болгосоор байна. Үүнд:

	Хүү (сар)	Дээд хэмжээ	Хугацаа (сар)
Ногоон амины орон сууцны зээл	1.25%-1.4%	160-300 сая төгрөг	120-240
Автомашины ногоон зээл	1%-1.1%	Бүтээгдэхүүний үнийн дүнгээс хамаарна	30-96
Ногоон хэрэглээний зээл	1.25%	20 сая төгрөг	30



Санхүүгийн хүртээмж

Голомт банкны бүтээгдэхүүн, үйлчилгээг нийгмийн бүх бүлэгт цаг алдалгүй, хүртээмжтэй авах боломжийг олгох нь Тогтвортой Хөгжлийн Зорилгуудыг хэрэгжүүлэх гол хөшүүрэг гэж үздэг. НҮББОХ – Санхүүгийн санаачилгаас гаргасан аргачлалыг ашиглан багцын нөлөөллийн шинжилгээг бүтээгдэхүүний төрлөөр ангилан хийж гүйцэтгэсэн ба дараах Тогтвортой Хөгжлийн Зорилгуудын хэрэгжилтэд хувь нэмрээ оруулж байна гэсэн үр дүн гарсан болно. Бид нийгмийн илүү олон бүлэгт хэрэгцээ шаардлагад нь нийцсэн, хариуцлагатай, тогтвортой байдлаар ашиг тустай, хүртээмжтэй санхүүгийн бүтээгдэхүүн, үйлчилгээг авах боломжийг хангахыг зорин ажиллаж байна.



Хүртээмж багатай бүлэгт таатай орчин бүрдүүлэх

ATM болон CDM төхөөрөмжийн хандах цэгүүд /Монгол Улс/



2023 оны эцсийн байдлаар банкны бүтээгдэхүүн үйлчилгээний хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой хот болон орон нутагт 293 болон 133 ATM, киоскуудыг байршуулан ажиллалаа.

- Улаанбаатар 293 ATM болон CDM
- Төв аймаг 2 ATM болон CDM
- Дархан-Уул аймаг 18 ATM болон CDM
- Сүхбаатар аймаг 5 ATM болон CDM
- Дорноговь аймаг 13 ATM болон CDM
- Дорнод аймаг 7 ATM болон CDM
- Орхон аймаг 22 ATM болон CDM
- Архангай аймаг 5 ATM болон CDM
- Хөвсгөл аймаг 12 ATM болон CDM
- Өвөрхангай аймаг 5 ATM болон CDM
- Баянхонгор аймаг 6 ATM болон CDM
- Ховд аймаг 6 ATM болон CDM
- Баян-Өлгий аймаг 4 ATM болон CDM
- Увс аймаг 4 ATM болон CDM

Хүртээмж багатай бүлэгт таатай орчин бүрдүүлэх

ATM болон CDM төхөөрөмжийн хандах цэгүүд /Улаанбаатар хот/



- Сүхбаатар дүүрэг 58 ATM болон CDM
- Чингэлтэй дүүрэг 28 ATM болон CDM
- Сонгинохайрхан дүүрэг 39 ATM болон CDM
- Баянзүрх дүүрэг 61 ATM болон CDM
- Хан-Уул дүүрэг 52 ATM болон CDM
- Баянгол дүүрэг 49 ATM болон CDM
- Багануур дүүрэг 5 ATM болон CDM



Дижитал шилжилт

Дижитал шилжилт нь банкны хувьд үйл ажиллагааны болон гүйлгээний зардлыг бууруулах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх, санхүүгийн салбар болон хүртээмж багатай бүлгүүд болох эмэгтэйчүүд, хүүхдүүд, малчид, алслагдсан бүс нутагт оршин суугаа иргэд, бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн хэрэгцээг хангах, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх боломжийг олгож байдаг. Ухаалаг утсыг ашиглан цахим үйлчилгээ авах боломжгүй иргэдэд салбар тооцооны төвүүд болон киоскуудаар дамжуулан бүтээгдэхүүн, үйлчилгээг хүргэсээр байна.

2023 онд өөрийн нийт дижитал сувагт 320 орчим хөгжүүлэлтийг хийснээс 85 хувь нь шинэ сайжруулалт, үйлчилгээний боломжийг тэлэхэд чиглэсэн бол 15 хувь орчим нь харилцагчийн туршлагад үндэслэсэн "Алдаагүй дижитал банк" зорилтын хүрээнд хийгдсэн сайжруулалтын ажлууд байв.



SocialPay 3.0

Монголын анхны дижитал хэвтэвч SocialPay аппликэйшнээ банк 2023 онд шинэчлэн шинэ өнгө дизайн дэлхийн чиг хандлагын олон шийдлийг агуулсан 3.0 хувилбарыг зах зээлд амжилттай нэвтрүүллээ. Ингэснээр бүх банкны данс руу шилжүүлэг хийхээс гадна QPAY-ын бүх төрлийн QR кодыг SocialPay-ээр уншуулан төлбөр тооцоо хийх боломжтой болсноор Монголын хамгийн олон дэлгүүрт ашиглагдах боломжтой дижитал хэвтэвч болов. Мөн БНХАУ-д Virtual UnionPay картын QR кодоо ашиглан төлбөр тооцоо хийх боломжтой болсон юм.



SocialPay Junior

Хүүхэд залууст зориулсан SocialPay Junior аппликэйшныг залуусын хэрэгцээнд нийцүүлэн зах зээлд амжилттай нэвтрүүллээ. Хүүхэд залуус өөрсдийн сонирхолд нийцүүлэн өнгө төрхийг нь өөрчлөн удирдах, виртуал карт захиалах, биет картаа холбон төлбөр тооцоо зайнаас хийх, мөнгө нэхэмжлэх, шилжүүлэх болон өөрийн дансыг удирдах зэргээр санхүүгийн хэрэгцээг бүрэн хангаж нэвтрүүлэв.

Дижитал сувгийн бусад онцлох бүтээгдэхүүн, үйлчилгээ

- 2023 онд дижитал зээлийн төслийг хэрэгжүүлэн дижитал сувгуудаар цалин, хэрэглээний зээл, ПОС барьцаалсан зээл, тэтгэврийн зээлийг дижитал сувгуудаар хурдан шуурхай авах боломжийг бүрдүүллээ. Ингэснээр цалин, хэрэглээний зээлийн 25% нь дижитал руу шилжсэн байна.
- 2023 оны 4-р сард Төрийн банктай, 2023 оны 9-р сард Капитрон банктай хамтран ажиллах гэрээ байгуулж, банкуудын картууд харилцан АТМ төхөөрөмжүүд дээр гүйлгээ хийх үед шимтгэлийг 100 төгрөг болгон буурууллаа.
- УБЕГ-ын өөртөө үйлчлэх төхөөрөмжүүдэд төлбөр төлөх шийдлийг холбож, нэвтрүүлэв.
- Байгууллага интернэт банкаараа багц гүйлгээ, Visa B2B зэрэг гүйлгээг хийх боломжтой болов.

Жижиг дунд бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадварыг бэхжүүлэх

Голомт банк нь бичил, жижиг, дунд бизнес эрхлэгчдийн өрсөлдөх чадвар болон санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх зорилготой Байгууллага хөгжлийн газрыг бүтцийн өөрчлөлт хийн байгууллаа. Тайлант жилд олгосон нийт бичил, жижиг, дунд зээлийн 97% нь бичил болон жижиг бизнес эрхлэгч нар байсан. Үүнээс гадна 2023 оны байдлаар зах зээлд нэвтрүүлсэн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зээлийн бүтээгдэхүүнийг 500+ зорилтот харилцагчдад хүргэн өмнөх онтой харьцуулахад 74 хувийн өсөлтийг үзүүлээд байна.

Жижиг, дунд бизнес эрхлэгчдэд үйл ажиллагаагаа амжилттай өргөжүүлж бизнесээ дараагийн шатанд гарахад нь зөвлөн дэмжих зорилгоор банк “Менторшип” хөтөлбөрийг 2 дахь жилдээ хэрэгжүүллээ. Ингэснээр:

- Бизнес эрхлэгч 225 эмэгтэйг 12 удаагийн сургалтад хамруулж, 78 бизнес эрхлэгчийг 7 удаагийн нетворкинг арга хэмжээнд оролцууллаа. Мөн 191 бичил бизнес эрхлэгчдэд зөвлөх үйлчилгээ үзүүлж, нийслэл болон орон нутгийн бизнес эрхлэгч 53 эмэгтэйд “Бизнес инкубатор үйлчилгээ”-г тус тус үзүүллээ.
- Нийслэл болон орон нутгийн бизнес эрхлэгч нийт 380 эмэгтэй Санхүүгийн удирдлага, Хямралын үеийн санхүүгийн удирдлага, Онлайн төлбөр тооцоо, Дижитал маркетинг, Харилцааны ур чадвар, Бүтээлч менторшип хөтөлбөр зэрэг нийт 37 төрлийн санхүүгийн болон хувь хүний хөгжлийн 16 удаагийн давтамжтай сургалтад хамрагдлаа.



Бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийг дэмжих зорилгоор МҮХАҮТ-тай хамтран гаргасан “Women Owned” тохирлын тэмдэгтийг албан ёсоор 2023 онд олон нийтэд танилцуулж, хэрэглээнд нэвтрүүллээ. Ингэснээр Голомт банк энэ төрлийн тохирлын тэмдгийг Монгол Улсад гаргаж буй анхны байгууллага болсон юм. “Women Owned” тохирлын тэмдэгтийг бараа бүтээгдэхүүн, үйлчилгээндээ байршуулснаар тухайн бизнесийн үйл ажиллагааг эмэгтэй хүн эрхлэн явуулдаг гэдгийг шууд илэрхийлнэ. Мөн бизнес эрхлэгч эмэгтэйчүүдийн бүтээгдэхүүн, үйлчилгээг олон нийтэд таниулах, худалдан авалтыг нэмэгдүүлэхээс гадна цаашлаад олон улсын зах зээлд гарахад томоохон дэмжлэг болох юм.

Энэхүү тохирлын тэмдэгтийг зах зээлд нэвтрүүлснээр ТХЗ 5: Жендэрийн тэгш байдлыг хангах, ТХЗ 8: Зохистой хөдөлмөр ба эдийн засгийн өсөлтийг дэмжих, ТХЗ 10: Тэгш бус байдлыг бууруулах зорилгуудын хэрэгжилтийг хангахад хувь нэмрээ оруулан ажиллаж байна. Мөн нэмэлтээр Алсын Хараа 2050 урт хугацааны хөгжлийн бодлогын Зорилго 3 буюу Хөдөлмөр эрхлэлт ба гарааны бизнес болон Зорилго 4 буюу Дундаж давхаргыг дэмжсэн санхүүжилт зорилгуудын хэрэгжилтийг хангахад хувь нэмрээ оруулж байна.






БАНКНЫ ӨДӨР ТУТМЫН
ҮЙЛ АЖИЛЛАГААГ
ТОГТВОРТОЙ, НОГООН БОЛГОХ




Байгаль орчин

Голомт банк нь өөрийн үйл ажиллагаанаас үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах, нөөцийг хариуцлагатай, тогтвортой ашиглах замаар байгаль орчинд үзүүлж буй сөрөг нөлөөллийг багасгах үүрэг хариуцлагыг хүлээн ажиллаж байна. Үүний хүрээнд бид өөрийн үйл ажиллагаанаас ялгаруулж буй хүлэмжийн хийн ялгарлын хэмжээг 2030 болон 2050 он гэхэд 30 болон 50 хувиар тус тус бууруулах зорилтуудыг баталсан юм.



Банк нь өөрийн үйл ажиллагаанаас ялгаруулж буй хүлэмжийн хийн хэмжээг дараах байдлаар ангилан тооцдог. Үүнд:

1. Хамрах хүрээ 1 буюу өөрийн эзэмшлийн болон түрээсийн тээврийн хэрэгслийн түлшний зарцуулалт
2. Хамрах хүрээ 2 буюу оффис, салбаруудын эрчим хүч, дулааны ашиглалт
3. Хамрах хүрээ 3 (бусад) буюу 2023 оны байдлаар бизнес аялал, ажилтнуудын гэр ажлын хооронд зорчиж буй хэлбэр, хог хаягдал, усны ашиглалттай холбоотой ялгаруулалтыг тооцоолж байна.



Эрчим хүчний хэмнэлт

Нүүрс нь эрчим хүчний үндсэн эх үүсвэр тул эрчим хүчний хэрэглээ нь хүлэмжийн хийн ялгарлыг бий болгож буй нөлөө өндөртэй хүчин зүйл тул эрчим хүчний хэмнэлтийг бий болгох чиглэлээр анхаарал хандуулан ажиллаж байна. 2023 онд Голомт банкны оффисууд 1,181,445 кВт эрчим хүч (2022: 1,379,706 кВт) хэрэглэсэн бөгөөд төвийн нэгдсэн эрчим хүчний сүлжээнээс 100 хувь хангасан байна. Голомт банк нь сард 1080 кВт-ын хүчин чадалтай нарны панелиг оффис дээр суурилуулснаар 2023 онд 6,376 кВт (2022: 5,987 кВт) эрчим хүчийг сэргээгдэх эрчим хүчнээс хангасан байна. Мөн, LED гэрлүүдийг үе шаттайгаар суурилуулж, ажилтнуудыг мэдлэг мэдээллээр ханган ажиллаж байна.

Бид үйл ажиллагааныхаа эрчим хүчний үр ашгийг дээшлүүлэхээр зорьж байгаа бөгөөд 2030 болон 2050 он гэхэд үйл ажиллагааныхаа эрчим хүчний үр ашгийг дор хаяж 30 хувь болон 50 хувиар тус тус бууруулах зорилтуудыг дэвшүүлэн ажиллаж байна. Мөн, салбаруудын эрчим хүчний хэрэглээний өгөгдлийг боловсруулан гаргах боломжийг бүрдүүлэх ажлыг эхлүүлээд байна.

Ханган нийлүүлэлтийн сүлжээ

Банк нь өөрийн үйл ажиллагаанаас шууд үүдэлтэй хүлэмжийн хийн ялгарлаас гадна өөрийн ханган нийлүүлэлтийн сүлжээ дахь хүлэмжийн хийн ялгарлыг бууруулах чиглэлээр ханган нийлүүлэгчидтэй нягт хамтран ажиллах нь чухал гэдгийг хүлээн зөвшөөрч анхааран ажиллаж байна. Монгол Улсын тэргүүлэгч банкнуудын төлөөллийн хувьд бид өдөр тутмын үйл ажиллагаандаа шаардлагатай программ хангамж, байгууллагын үйлчилгээ, бусад материал зэрэг олон төрлийн бүтээгдэхүүн, үйлчилгээг худалдан авдаг. Иймээс Монгол Улсын Тогтвортой санхүүгийн зарчмуудад нийцүүлж дотоодын үйлдвэрлэгчдээс худалдан авах зарчим баримтлан ажилладаг ба тогтвортой байдлын заалтуудыг одоогийн Худалдан авалтын үйл ажиллагааны журамдаа амжилттай нэгтгэсэн юм.

Худалдан авалт	2023	2022	2021
Дотоодоос нийлүүлсэн, худалдан авсан (жижиг, дунд бизнес эрхлэгчид, эмэгтэй бизнес эрхлэгчид)	95%	96.2%	70%
Гадаадаас нийлүүлсэн, худалдан авсан	5%	3.8%	30%

Бид худалдан авалтын үйл ажиллагааны журмаа сайжруулж, хүлэмжийн хийн ялгарлыг бууруулахад шаардлагатай алхмуудыг ханган нийлүүлэгчидтэйгээ хамтран хэрэгжүүлсээр байх болно.

Усны хэмнэлт

Голомт банкны дийлэнх оффисууд болон салбарууд түрээснийх ба бусад түрээслэгчидтэй хамтран байрладаг онцлогтой. Банкны усны хэрэгцээг унд ахуйн стандартын шаардлагад тохирсон цэвэр усаар байнга тасралтгүй хангах, бохир усыг экологийн тэнцвэрийг хадгалах шалгуурт тохирох стандартын дагуу цэвэрлэж зайлуулах үйл ажиллагааг Ус сувгийн



удирдах газар хариуцан нэгдсэн байдлаар ажилладаг. Иймээс, банк нь өөрийн усны хэрэглээг бууруулах чиглэлээр авч хэрэгжүүлж буй ажлууд дээр анхаарал хандуулан ажиллаж байна. Үүний хүрээнд, шинээр ашиглалтад орох болон засварын ажил төлөвлөгдсөн салбарууд болон оффисууд дээр автомат болон усны хэмнэлттэй цоргонууд байршуулах, бусад боломжит усны хэмнэлттэй техник технологийг нэвтрүүлэхээр ажиллаж байна.

Бид өөрсдийн салбар болон оффисуудын усны хэрэглээг 2030 он болон 2050 он гэхэд 5 болон 10 хувиар бууруулах дунд болон урт хугацааны зорилтуудыг тавин хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тогтвортой хог хаягдлын менежмент

Банкны оффисууд болон салбар тооцооны төвүүд өдөр тутамдаа дахин боловсруулагдах хог хаягдал, ердийн ахуйн хог хаягдал болон бага хэмжээний ахуйн аюултай хог хаягдал болох батарей, чийдэн зэрэг хаягдлыг бий болгож байна. Банкны салбар, оффисуудын дийлэнхийг түрээсийн байр эзэлдэг бөгөөд бусад түрээслэгчидтэй хамт байрладаг тул ердийн ахуйн хог хаягдлын мэдээллийг оффисын ажилтны өдрийн дундаж хог хаягдал үүсгэж буй үзүүлэлтээр тооцон гаргаж байна. Бид банкны эзэмшлийн хоёр оффис дахь хуванцар, хөнгөн цагаан лааз, шил болон цаасыг дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлж, ахуйн аюултай хог хаягдлыг стандартын дагуу тушааж, харин электрон хог хаягдлын менежментээ сайжруулахаар анхааран ажиллаж байна.

Өөрийн эзэмшлийн хоёр оффис дахь хог хаягдлыг дахин боловсруулах үйлдвэрүүдэд нийлүүлэхээс гадна цаас, нэг удаагийн цаасан болон хуванцар бүтээгдэхүүний хэрэглээг бууруулах, цаашлаад банкны хэмжээнд халах зорилго тавин ажиллаж байна.

Хэрэгжилтийг хангах суурь нөхцөл

Бид тогтвортой хөгжлийн бодлогоо хэрэгжүүлж, Үндэсний зорилтот хувь нэмэр болон Тогтвортой хөгжлийн зорилгуудын хэрэгжилтэд оруулж буй хувь нэмрээ нэмэгдүүлэхийн тулд дотоод чадавхаа болон олон талт харилцааг бэхжүүлэн ажиллаж байгаа юм. Үүний хүрээнд:

1. Чанартай, үнэн зөв БОНЗ-ын өгөгдөл цуглуулах
2. Мэдлэгээ хуваалцах, бусдыгаа үлгэрлэн манлайлахад ач холбогдол өгч байна.

БОНЗ-ын өгөгдөл

Банкны тавьсан зорилтууд, тогтвортой байдал, уур амьсгалын эрсдэлийн удирдлагын тайлагналын зохицуулалт, шаардлагууд нэмэгдэж байгаатай холбогдуулан хэрэгцээт өгөгдлийн цар хүрээ тэлсээр байгаа юм. Иймээс БОНЗ-ын өгөгдлийг цуглуулах нэгдсэн системийн боломжит шийдлийг тодорхойлох хариуцлагатай ажлыг эхлүүлэхээр төлөвлөн ажиллаж байна.





МЭДЛЭГЭЭ
ХУВААЛЦАХ, БУСДЫГАА
МАНЛАЙЛАХ НЬ



Тогтвортой санхүүжилтийн долоо хоног 2023 олон улсын форум

/2023 оны 6-р сарын 13-16/

ТоС Холбооноос Монгол Улсын Ерөнхийлөгчийн Тамгын Газар, бусад түнш дэмжигч байгууллагуудтай хамтран “Тогтвортой санхүүжилтийн долоо хоног 2023 (ТоС долоо хоног)” цуврал семинар, олон улсын манлайллын хөтөлбөр, өндөр түвшний бодлогын хэлэлцүүлэг бүхий форум арга хэмжээг 500 гаруй оролцогчидтойгоор зохион байгууллаа. Энэхүү арга хэмжээний үеэр Голомт банкны Гүйцэтгэх Захирал Норихико Като уур амьсгалын эрсдэлийн удирдлага болон Байгаль орчин нийгмийн эрсдэлийн дүн шинжилгээний ач холбогдол болон аргачлалын талаарх сайн туршлагаа амжилттай хуваалцлаа.



Тогтвортой хөгжлийн төлөөх үндэсний чуулган


/2023 оны 9-р сарын 7/



Монгол Улсын Засгийн Газар, тэр дундаа Эдийн Засаг Хөгжлийн Яамны манлайллын дор, Үндэсний үүрэг амлалтын төслийг танилцуулах, Тогтвортой хөгжлийн зорилгуудын хэрэгжилтийг эрчимжүүлэх, үүний тулд эвлэлдэн нэгдэх, хэнийг ч орхигдуулахгүй байх талаар оролцогч талууд санал солилцож, цаашдын хамтын ажиллагааг бэхжүүлэхээр нэгдлээ. Энэхүү арга хэмжээний үеэр Голомт банк нь Монгол Улсын тогтвортой хөгжлийн төлөөх хичээл зүтгэлд хувь нэмрээ оруулж, үндсэн үйл ажиллагааныхаа үндсэн чиглэл болгон ажиллаж буй сайн туршлагаасаа хуваалцлаа.

Financial Managers' Convention and Business Conference

/2023 оны 10-р сарын 3-4/



Жил бүр уламжлал болгон зохион байгуулдаг “Financial Managers’ Convention” арга хэмжээг “Think Globally, Act Locally” уриан дор 5 дахь жилдээ амжилттай зохион байгууллаа. Уг арга хэмжээний гол зорилго нь тухайн жилийн эдийн засаг, санхүүгийн үр дүн, түүнд нөлөөлсөн хүчин зүйлсийг дүгнэж, ирж буй жилүүдийн эдийн засгийн төлөв байдлын талаар хэлэлцэж, оролцогчид туршлагаа хуваалцдаг. 2023 оны тухайд арга хэмжээний онцлох хөтөлбөр болох панель хэлэлцүүлгийг “Тогтвортой санхүүжилт” сэдвээр явуулж, жил ирэх бүр бизнесийн салбарт хүчтэй нөлөөлөх болсон тогтвортой санхүүжилтийн талаарх ойлголтыг хамтдаа хэлэлцэв. Энэхүү арга хэмжээний үеэрх хэрэглэсэн эрчим хүчийг – тэр дундаа LED дэлгэц, босоо дэлгэц, гэрэлтүүлэг, хөгжим болон бусад тоног төхөөрөмжүүдийг - нарны эрчим хүчээр цэнэглэсэн хураагуураар хангасан юм. Ингэснээр цагт 28.3кгCO2 тэнцэх хүлэмжийн хийн ялгарлыг бий болгохоос сэргийлсэн байна. Мөн оролцогчдыг тогтвортой, ногоон тээврийн хэрэгслийг сонгон ирэхийг уриалсан ба нийт 51.6кг CO2-тэй тэнцэх хэмжээний хүлэмжийн хийн ялгарлыг бий болгохоос сэргийлсэн байна. Банк нь нийт харилцагчид болон оролцогч талуудтай хамтран нэг мод арван нэгэн жилийн турш шингээх боломжтой 278кг CO2-ийг ялгаруулахаас зайлсхийж чадсан билээ.



Нийгэм

БОНЗ нь хөрөнгө оруулагчид, харилцагчид, ажилтнууд, хэвлэл мэдээллийн хэрэгслүүдийн анхаарлыг ихээр татаж, харгалзан үзэх чухал сэдэв болсон ба банк ч мөн адил тогтвортой хөгжил болон тогтвортой санхүүжилтийг үндсэн стратегийн нэгээр тунхагласан билээ. Үндэсний зорилтот хувь нэмэр, уур амьсгалын өөрчлөлт зэрэг байгаль орчинтой шууд холбоотой асуудлууд бий хэдий ч нийгэм – тэр дундаа ажлын байртай холбоотой олон асуудлуудыг мөн харгалзан авч үздэг. Олон талт, тэгш, хүртээмжтэй, үл ялгаварласан, хүний эрхийг дээдэлсэн үйл ажиллагаа эрхлэх нь банкны хүний нөөцийг бүрдүүлэхэд чухал ач холбогдолтой гэдэгт итгэдэг. Голомт банк нь жендэрийн тэгш байдал, БОНЗ, ТХЗ, хүний эрхийн асуудлуудыг холбогдох бодлого, журам, бусад бичиг баримтуудад тусган, сайжруулалтыг хийн ажиллаж байгаа ба дэлгэрэнгүй баримт бичгийг хүснэгтийн тодруулга хэсгээс харна уу.

Шилдэг байгууллагын соёлыг бүрдүүлэх нь

Урамшуулал

Ажилтнуудынхаа эрүүл мэндийг хамгаалах

- Жил бүр зохиогддог “Витаминжуулах аян” арга хэмжээнд 1,063 ажилтан хамрагдсан
- Оффисын эмчээр дамжуулан 1,275 ажилтан, албан хаагчдад эмнэлгийн анхан шатны тусламж үйлчилгээ үзүүлсэн
- 2,494 ажилтан хувийн даатгалд хамрагдсан

Хөгжлийн бэрхшээлтэй хүмүүсийн ажлын байр, санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх

- Хөгжлийн бэрхшээлтэй 23 албан хаагчийг ажлын байраар хангав
- Ажлын байрны ослын улмаас 503 ажилтанд нэмэлт санхүүгийн дэмжлэг үзүүлэв

Өндөр настай ажилтнуудын санхүүгийн хүртээмжийг нэмэгдүүлэх

- Өмнө нь ажиллаж байсан 5 иргэнд санхүүгийн тэтгэврийн дэмжлэг үзүүлж байна

Ажил амьдралын баланс

- Уян хатан ажлын цаг
- Ажилтнуудын цалин 30 хувь хүртэл өсөв
- Сонирхлын клубүүд, спорт соёлын арга хэмжээ, хичээлүүдэд хамрагдах боломжууд

Ажилтан болон тэдний гэр бүлийг дэмжих бодлого

- Ажилтны өөрийн болон хүүхдүүдийн төрсөн өдрийн цалинтай чөлөө
- Зуны улиралд ажилтнууддаа цэвэр агаарт гэр бүлээрээ гарч, амрах “Ойн булаг зуслан”
- 47 ажилтан уян хатан нөхцөлтэй ипотекийн зээлд хамрагдах боломжтой болсон



Ажилтнуудын сургалт, хөгжил

Бид ажилтнууддаа урт хугацааны карьерын хөгжлийг бий болгож, харилцагч болон үйлчлүүлэгчтэйгээ тогтвортой, үр ашигтай харилцааг бий болгохыг зорьж байна. Дэлхий нийтийг хамарсан өөрчлөлтүүд - зайнаас ажиллах сонирхол, үе хоорондын ялгаатай байдал үргэлжилсэн ч бид ажилтнуудынхаа хөгжил, дэвшилд хувь нэмрээ оруулах үүрэг хариуцлагаа хүлээн ажилласан хэвээр байна. Жил бүр Голомт банкны ажилтнуудын ур чадвар, хүний нөөцийн чадавх, ажилтнуудынхаа сэтгэл ханамжийн түвшинг судалж, бизнесээ дэмжин ажилладаг ба 2023 онд Great Place To Work Institute-ээс "Ажиллахад хамгийн таатай газар" батламжийг 2 дахь жилдээ гардан авсан.

Ирээдүйн ажиллах хүчээ бэлтгэх нь

Царт тахлын үр нөлөөгөөр шинэ ажлын арга барилыг эрэлхийлж байгаа энэ үед бид олон түвшний сургалтаар дамжуулан ажилтнуудаа ирээдүйд бэлэн, эрэлт хэрэгцээнд нийцсэн ажиллах хүч болгон бэлдэхийг зорин ажилладаг. 2023 онд нийт 164,738 хүн/цагийг дотоодын болон олон улсын сургалтад зориулав. Бид ажилтнуудынхаа ирээдүйн карьерын өсөлтийг дэмжих зорилгоор өгөгдөл, цахим шилжилт, удирдахуй гэх мэт хэрэгцээт ур чадваруудыг бэхжүүлсээр байна.

Ажил мэргэжлийн өсөлтийн олон боломжуудыг бүрдүүлэх нь

Ажилтнуудыг урт хугацаанд, таатай ажлын байраар ханган ажиллахаас гадна өөрсдийн олон шатлалт сургалтын стратегиар дамжуулан ажилтан бүрийн хүсэл сонирхол, эрмэлзлийг харгалзан хөгжүүлдэг. Иймээс, банк нь дан ганц босоо шилжилт бус хөндлөн шилжилтийг хийх боломжуудыг нээж, ажилтнууд хэлтэс, бизнес хооронд шилжих боломжийг олгодог. Ингэснээр ажилтнууд өөр өөр ур чадвар, туршлага олж авах замаар ажил мэргэжлийн хөгжлийг эрчимжүүлэх, өөрчлөлтийг хийх боломжийг бүрдүүлэн ажиллаж байна.

Удирдлагын манлайллыг хөгжүүлэх нь

Тасралтгүй суралцах соёлыг баримтлан ажилладаг тул удирдлагын түвшний 1,900 ажилтан Гүрүн Академитай хамтран Global Growth Institute-ээс гаргасан "World Class Manager Vol2" хөтөлбөрт хамрагдсан байна.



Олон талт, тэгш, хүртээмжтэй байдлыг хангах нь

Голомт банкны хувьд олон талт, тэгш, хүртээмжтэй байдлыг эрхэмлэснээр чадварлаг, шилдэг багийг бүрдүүлж, хамгийн сайн ажлын үр дүн гаргах боломжийг бүрдүүлдэг. Бид тэгш боломжоор хангах, хүн бүр өөрийн чадавхдаа хүрч хөгжих, аерэг өөрчлөлтийг бий болгох, хүртээмжтэй соёлыг бий болгохыг зорьж байна. Банк нь ялгаварлан гадуурхалт, дарамт шахалтаас ангид ажлын орчныг бий болгохыг эрмэлзэн хэрэгжилтийг ханган ажиллаж байна.

Тэгш боломжийг бий болгох нь

Бид одоогийн ажилтнууд болон ирээдүйд бидэнтэй нэгдэх ажилтнууддаа тэгш боломжийг олгох үүрэг амлалт өгсөн. Бид хүмүүсийг нас, арьсны өнгө, хүйс, шашин шүтлэг, гэр бүлийн байдал, гэр бүлийн үүрэг хариуцлага, хөгжлийн бэрхшээлтэй эсэхээс үл хамааран ур чадвар, туршлага, ажил гүйцэтгэх чадварыг нь харгалзан ажилд авдаг. Нийт ажилтнуудын 23 нь хөгжлийн бэрхшээлтэй иргэд байдаг ба хөдөлмөрийн тухай хууль тогтоомж, дүрэм журмыг бид чандлан дагаж мөрддөг.

Хүртээмжтэй соёлыг бүрдүүлэх нь


Бид ажилтнууддаа хөрөнгө оруулалт хийдэг, анхаарал халамж тавьдаг, байгууллагад үнэ цэнтэй гэдгийг нь мэдрүүлэхийг зорьж, хүртээмжтэй соёлыг төлөвшүүлэхийг чухалчилдаг. Бид ажилтнууддаа аюулгүй, хүртээмжтэй ажлын байраар ханган, хамтын үнэ цэн, соёлыг бэхжүүлэхээр зорин ажиллаж байгаа билээ.

Голомт банк нь ажилтнуудын дундаас шударга ёс, харьяалагдах мэдрэмж, манлайллын талаарх ойлголтын талаар нэрээ нууцалсан судалгаанд үндэслэн олгодог “Ажиллахад хамгийн таатай газар” батламжийг хоёр дахь жилдээ гардан авлаа.

Хүний эрхийг дээдлэх нь

Харилцагчид, засгийн газар, иргэний нийгмийн байгууллагууд аливаа бизнесийн үйл ажиллагааг байгаль орчин болон нийгэмд сөрөг нөлөөгүй, тогтвортой, ёс зүйтэй байх шаардлагыг тавьсаар байна. Голомт банкны хувьд бизнесийн шударга ёс, хүний эрх, ёс зүй, байгаль орчин, хөдөлмөрлөх эрхийн хүрээнд хүний эрхийг хамгаалж, хүндэтгэхийг нийт ажилтнуудад уриалан, хандлагыг өөрчлөх ажлыг үе шаттайгаар хэрэгжүүлсээр ирсэн. Иймээс хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй олон улсын жишигт нийцүүлэн холбогдох бодлого, дүрэм журам, байгууллагын соёлоор дамжуулан олон улсын жишигт нийцүүлэхийн тулд үйл ажиллагаагаа явуулж, тасралтгүй сайжирсаар байна. Ирэх жилүүдэд бид БОН-ийн эрсдэлийн үнэлгээний үйл явц, худалдан авалтын үйл явц болон өөрийн үйл ажиллагаанд хүний эрхийн зарчмуудыг нийцүүлэн бэхжүүлж, сайжруулан ажиллахаар төлөвлөж байна.





СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 3:
УУР АМЬСГАЛЫН
ӨӨРЧЛӨЛТИЙН ЭРСДЭЛИЙН
УДИРДЛАГА



Харилцагчдын БОНЗ-ын эрсдэлийг удирдах нь


Голомт банк нь байгаль орчин, нийгмийн эрсдэлийг таних, хэмжих, үнэлэх, хянах, тайлагнах, бууруулах, удирдахад шаардлагатай банкны бодлого журмууд болон тогтолцоог ногоон эдийн засагт шилжих Үндэсний төлөвлөгөөтэй уялдуулан байгаль орчны холбогдох хууль тогтоомж, бодлого журамд нийцүүлэн үйл ажиллагаанаас учирч болох эрсдэлийг удирдаж байна. Мөн, Олон Улсын Санхүүгийн Корпорацийн стандартуудтай нийцүүлэн сайжруулж байна.

Банк нь бизнесийн цар хүрээ, шинж чанарт нь тохирсон байгаль орчин, нийгмийн эрсдэлийн засаглалын бүтцийг бий болгож, удирдлагын хариуцлагыг хамгаалалтын гурван шугамаар тодорхойлсон.



Эрсдэлийг тодорхойлох

Голомт банк нь харилцагч байгаль орчин болон нийгмийн эрсдэлээ тодорхойлох болон удирдах чадамжийг харгалзан А, В, С гэсэн гурван үндсэн ангилалд ангилан үнэлдэг. Мөн эрсдэл өндөртэй бизнесийн үйл ажиллагаанд нарийвчилсан үнэлгээг хийж, эргэн хяналтуудыг жил бүр хийж байна.



Эрсдэлийг хэмжих

Банк нь багцын түвшинд БОНЗ-ын хэрэгжилтийг хэмжих, үнэлэх, хянах, удирдах, салбар бүрээр нь дүн шинжилгээ хийх зорилготой тоон болон чанарын үзүүлэлтүүдийг тогтоон ажиллаж байна. Үүнд:

1. Хүлэмжийн хийн ялгарал өндөр салбаруудын зээлийн үлдэгдэл, хувь хэмжээг улирал бүр хянах
2. Харилцагчийн БОНЗ-ын эрсдэлийн нөлөөллийг үнэлэх

Эрсдэлийг хянах

Голомт банк нь байгаль орчин, нийгмийн эрсдэлийг зохих ёсоор бууруулсан эсэхийг батлахын тулд БОНЗ-ын эрсдэлтэй холбоотой гэрээнд тусгагдсан нөхцөлүүдийн хэрэгжилтэд хагас жил болон жил тутам хяналт тавин ажиллаж байна.

Санхүүжилт олгохоос татгалзах, анхаарах жагсаалтад орсон харилцагчид

Дараах нөхцөл байдлын аль нэг банк нэмэлт санхүүжилт олгохоос татгалзана.

1. Хориотой үйл ажиллагааны жагсаалтад орсон бол
2. Санхүүжилт олгогдсон харилцагчдын хувьд БОН эрсдэлийг бууруулах нөхцөлийг Гэрээнд тусгаснаар биелүүлээгүй бол

Тайлант онд нийт 1,177 байгаль орчин, нийгмийн эрсдэлийн үнэлгээг хийсэн ба өмнөх оноос 107 хувийн өсөлтийг үзүүлсэн байна. Нийт хийсэн үнэлгээний 64 хувь нь эрсдэлгүй салбаруудад харьяалагдах санхүүжилтийн хүсэлт байсан ба үүнээс 74 хувьд нь санхүүжилт олгогдсон байна. Үлдсэн 36 хувийн үнэлгээ нь байгаль орчин ба нийгэмд нөлөөлөх нөлөө өндөр салбаруудад харьяалагдах санхүүжилтийн хүсэлт байсан ба үүнээс 62 хувьд нь санхүүжилт олгогдсон байна.

БОНЭУ хийсэн болон санхүүжилт олгосон тоо



БОН Эрсдэлийн үнэлгээ, эрсдэл өндөр салбараар



Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл ба боломжууд

Голомт банк нь уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн ач холбогдлыг ухамсарлан, эрсдэлийн удирдлагын тогтолцоонд биет болон шилжилтийн эрсдэлийг тодорхойлон тусгаж, нөлөөллийг тооцоолох нь чухал хэмээн үзэж байна. Иймээс, банк нь уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийг нийт банкны эрсдэлийн удирдлагын тогтолцоонд оруулж шинээр батлагдаад буй СТОУС S1 болон S2 стандартуудыг мөрдөх, тайлагнахаар төлөвлөн ажиллаж байна.


Биет эрсдэл

Энэ нь улам бүр нэмэгдэж буй уур амьсгалын гамшиг (үер, ган, халууны давлагаа гэх мэт), уур амьсгалын өөрчлөлт (жишээ нь: температурын өсөлт) болон экосистем алдагдах (жишээ нь цөлжилт, усны хомсдол, хөрсний доройтол) зэрэгт харилцагчийн бизнесийн үйл ажиллагаа, хөрөнгийн үнэ цэн болон бусад зүйлд сөргөөр нөлөөлөх эрсдэл юм.

Шилжилтийн эрсдэл

Энэ нь бодлогын өөрчлөлт, технологийн шинэчлэл, хэрэглэгчийн хүсэл сонирхолд өөрчлөлт орох, уур амьсгалын өөрчлөлтийн сорилтыг шийдвэрлэх үр дүнд хөрөнгө оруулагчдын үзэл бодолд өөрчлөлт орох нь харилцагчийн үйл ажиллагааны болон санхүүгийн нөхцөл байдалд нөлөөлөх эрсдэл юм.





СТРАТЕГИЙН ЗОРИЛГО 4:
ОЛОН ТАЛТ ОРОЛЦОО



Олон талт оролцооны зураглал

Банк санхүүгийн байгууллагын хувьд өөрийн үйл ажиллагаа, бүтээгдэхүүн үйлчилгээгээр дамжуулан байгаль орчин болон нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулахад оруулах хувь нэмэр өндөр салбарын нэг билээ. Иймээс, БОНЗ-ын хүрээнд оролцогч талуудын хүлээлтийг хангах чухал үүргийг хүлээгээд байна.

	Хөрөнгө оруулагчид	Харилцагчид	Ажилтнууд	Нийгэм	Зохицуулагч байгууллагууд
	Бид БОНЗ-ын тайлагналыг ил тод нээлттэй байдлаар тайлагнаж байна.	Бид харилцагчдынхаа хэрэгцээ шаардлагад нийцсэн бүтээгдэхүүн үйлчилгээг, түргэн шуурхай хүргэхээр ажиллаж байна.	Бид чадварлаг хамт олон бүрдүүлэх зорилгоор ажилтнуудаа хөгжүүлэн ажиллаж байна.	Бид нийгэмд тулгамдаад буй санхүүгийн асуудлууд, хүртээмжтэй байдлыг хэрхэн бий болгох талаар онцгойлон анхаарч ажиллаж байна.	Бид хууль, дүрэм журмын хүрээнд үйл ажиллагаагаа явуулж байна.
Бид хэрхэн хамтын ажиллагааг өрнүүлж байна вэ?	<ul style="list-style-type: none"> • Тогтвортой Хөгжлийн Тайлан /жил бүр/ • НҮББОХ-Банк Санхүүгийн Санаачилга, Хариуцлагатай Банкны Зарчмуудын хэрэгжилтийн тайлан /жил бүр/ • Санхүүгийн тайлангууд / улирал бүр, жил бүр/ 	<ul style="list-style-type: none"> • Салбар, дижитал сувгууд болон харилцагчийн үйлчилгээний утас гэх мэт олон сувагт харилцаа • Харилцааны болон Корпорэйт менежерүүд • Харилцагчдын сэтгэл ханамжийн судалгаа /жил бүр/ 	<ul style="list-style-type: none"> • Ажилтнуудын сэтгэл ханамжийн судалгаа /жил бүр/ • Ажиллахад таатай байгууллага батламж /жил бүр/ • Удирдах ажилтнуудад зориулсан арга хэмжээ /жил бүр/ 	<ul style="list-style-type: none"> • АмЧам, АустЧам, Монголын Бизнесийн Зөвлөл, Худалдаа Аж Үйлдвэрийн Танхимын гишүүн байгууллага ба үйл ажиллагаанд нь идэвхтэй оролцдог. • НҮБ болон холбогдох байгууллагуудтай хамтын ажиллагааг бэхжүүлж байна. 	<ul style="list-style-type: none"> • Монгол банк, Санхүүгийн зохицуулах хороо болон Хөрөнгийн биржтэй хамтран ажиллаж байна. • Эдийн засаг хөгжлийн яамтай хамтран ажиллаж байна.

Олон талт оролцоо

Голомт банк нь хурдацтай хувьсан өөрчлөгдөж буй БОНЗ-ын олон улсын стандарт, шаардлагуудтай нийцсэн байх, сайн туршлагаудаа оролцогч талуудтай хуваалцах үүднээс олон талт хамтын ажиллагааг өргөжүүлсээр байна.

Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо /MSFA

Монголын Тогтвортой Санхүүжилтийн Холбоо (ТоС) нь гишүүн санхүүгийн байгууллага, аж ахуйн нэгжүүдийн тогтвортой байдал, ногоон хөгжлийг дэмжих замаар санхүүжилтийн тогтолцоог ногоон болгох зорилготой ГҮТББ юм. Тус холбоо нь Тогтвортой хөгжлийн зорилтууд, Парисын хэлэлцээр, мөн Монгол Улсын тогтвортой хөгжлийн үзэл баримтлал, Үндэсний хэмжээнд тодорхойлсон хувь нэмэр, Ногоон хөгжлийн бодлого зэрэгт нийцүүлэн эерэг нөлөөллийг бий болгох нэгдсэн, болон хувьсах бодлого боловсруулах, бизнесийн арга барил, олон салбарын санаачилгыг боловсруулахад гишүүд, түншүүдтэйгээ нягт хамтран ажилладаг.

Голомт банк нь Удирдах зөвлөлийн гишүүн бөгөөд Уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэлийн зөвлөл болон тайлагналын зөвлөлд тус тус идэвхтэй хувь нэмрээ оруулж байна.



НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр-Санхүүгийн санаачилга, Хариуцлагатай банкны зарчмууд / UNEP-FI, PRB

НҮБ-ын Байгаль орчны хөтөлбөр, Санхүүгийн санаачилга нь НҮБ-ын Хариуцлагатай банкны зарчмуудаар дамжуулан олон улсын банкнуудтай хамтран ажиллаж эерэг, ногоон шилжилтийг хурдасгах зорилготой юм. Олон улсын банкны салбарын талаас илүү хувийг төлөөлж буй 330 гаруй банк гишүүнээр элссэн байдаг бөгөөд тус банкнууд нь НҮБ-ын Тогтвортой хөгжлийн зорилгууд болон Парисын гэрээ зэрэг олон улсын гэрээ хэлэлцээртэй үндсэн стратеги, шийдвэр гаргах, зээл олгох, хөрөнгө оруулалтын үйл ажиллагаагаа уялдуулдаг.

Голомт банк нь тус санаачилгыг үүсгэн байгуулагч гишүүний нэг бөгөөд Монгол Улсыг төлөөлөн дангаараа ажилладаг.

Нүүрстөрөгчийн Нягтлан Бодох Бүртгэлийн Санхүүгийн Түншлэл /Partnership for Carbon Accounting Financials (PCAF)

PCAF нь олон улсын банк санхүүгийн байгууллагуудыг санхүүжүүлсэн хүлэмжийн хийн ялгаруулалтыг тооцоолох, ил тод нээлттэй болгох нэгдсэн аргачлалаар ханган ажилладаг юм.

Голомт банк нь 2023 оны 2-р сард PCAF-ийн гишүүнээр элссэн бөгөөд PCAF аргачлалыг ашиглан нийт зээлийн багцын хүлэмжийн хийн ялгаруулалтыг тооцоод байна.

Шинжлэх ухаанд суурилсан зорилтуудыг тодорхойлох санаачилга /Science Based Targets initiative (SBTi)

SBTi нь Нүүрстөрөгчийн ил тод байдлын төсөл (CDP), НҮБ-ын Даян дэлхийн гэрээ, Дэлхийн нөөцийн хүрээлэн (WRI), Дэлхийн байгаль хамгаалах сан (WWF) хоорондын хамтын ажиллагаа бөгөөд хүлэмжийн хийн ялгаруулалтыг бууруулах, тэг ялгаруулалтад хүрэх олон улсын шилдэг туршлагыг тодорхойлж, сурталчлах зорилготой санаачилга юм. Нэмэлтээр байгууллагуудын тавсан зорилгуудын хөндлөнгийн хяналт үнэлгээг хийх үйлчилгээг үзүүлдэг.

Голомт банк нь SBTi-ээс олгосон хэрэгслийг ашиглан уур амьсгалын шинжлэх ухаанд нийцүүлэн дунд болон урт хугацааны зорилтуудаа тодорхойлон, Үндэсний зорилтод хувь нэмэртэй нийцүүлэн зорилтуудаа тодорхойлсон болно.

Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хамтын амлалт /Commitment to Climate Action (CCCA)

Уур амьсгалын өөрчлөлтийн эсрэг хамтын амлалт нь 2019 оны 9-р сард НҮББОХ-Хариуцлагатай банкны зарчмуудыг хэрэгжүүлэхээр нэгдсэн банк санхүүгийн байгууллагуудын бизнесийн стратегийг Парисын хэлэлцээрийн амлалтуудтай уялдуулан хурдасгах зорилготой байгуулагдсан.

Голомт банк нь CCCA-д нэгдэн орсон ба Парисын хэлэлцээрийн амлалтуудтай нийцсэн зорилго, зорилтуудыг батлан амжилттай ажилласан байна. Ингэснээр, нийт гишүүн банк санхүүгийн байгууллагууд зорилго, зорилтдоо хүрч энэхүү санаачилга нь 2023 онд хаагдсан.

Аргачлал

	Аргачлал	Холбоос
Хамрах хүрээ 1,2	Англи улсын 2023 онд шинэчилсэн коэффициентууд	энд дарна уу
Хамрах хүрээ 3 (бусад)	Эрчим хүчний зохицуулах хороо	энд дарна уу
Цахилгаан болон дулаан	Хамтын нөлөөллийн сан (JIM)	энд дарна уу

Тоон тодруулга Ажилтнуудын тоон мэдээлэл

Эрэгтэй vs Эмэгтэй (төрлөөр – бүтэн цагийн)

Тогтвортой хөгжлийн зорилго:



	2023			2022			2021		
	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт
Нийт ажилтнууд	1,747	747	2,494	1,662	744	2,406	1,241	675	1,916
Тусгай хэрэгцээт ажилтнууд	-	-	23	-	-	22	-	-	21
Нийт ажилтнууд	1,747	747	2,517	1,662	744	2,428	1,241	675	1,937

Эрэгтэй vs Эмэгтэй (албан тушаалаар)

Тогтвортой хөгжлийн зорилго:



Гэрээний төрөл	2023			2022			2021		
	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт
Удирдах түвшний захирал	7	12	19	5	13	18	5	14	19
Хэлтэс, салбарын захирал	60	64	124	66	77	143	60	65	125
Ажилтнууд	1,680	671	2,374	1,591	654	2,267	1,176	596	1,793
Нийт	1,747	747	2,517	1,662	744	2,428	1,241	674	1,927

Эрэгтэй vs Эмэгтэй (байршлаар)

Тогтвортой хөгжлийн зорилго:



	Бүтэн цагийн	Эмэгтэй	Эрэгтэй
Баруун бүс	78	48	30
Баян-Өлгий	26	13	13
Говь-Алтай	-	-	-
Завхан	-	-	-
Увс	15	11	4
Ховд	37	24	13
Хангайн бүс	116	76	40
Архангай	12	8	4
Баянхонгор	17	9	8
Булган	-	-	-
Орхон	44	32	12
Өвөрхангай	19	11	8
Хөвсгөл	24	16	8
Төвийн бүс	161	119	42
Говьсүмбэр	-	-	-
Дархан-Уул	47	31	16
Дорноговь	47	41	6
Дундговь	-	-	-
Өмнөговь	54	38	16
Сэлэнгэ	13	9	4
Төв	-	-	-
Зүүн бүс	42	27	15
Дорнод	29	20	9

Сүхбаатар	13	7	6
Хэнтий	-	-	-
Улаанбаатар	2,097	1,477	620
Нийт	2,494	1,747	747

Эгнээндээ нэгтгэсэн шинэ ажилтнууд/дадлагажигч

Тогтвортой хөгжлийн зорилго:



Төрөл	2023			2022			2021		
	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт	Эмэгтэй	Эрэгтэй	Нийт
Шинэ төгсөгчид			282			281			206
Дадлагын оюутан			290			35			45
Нийт			572			316			251

Байгаль орчинтой холбоотой тоон мэдээлэл

Тогтвортой хөгжлийн зорилго:



ЭРЧИМ ХҮЧ	2023			2022			2021		
	Оффисууд	Салбарууд	Нийт	Оффисууд	Салбарууд	Нийт	Оффисууд	Салбарууд	Нийт
Нийт эрчим хүчний хэрэглээ (кВт)	1,181,445	-	1,181,445	1,379,706	-	1,379,706	1,429,886	-	1,429,886
Нийт сэргээгдэх эрчим хүчний хэрэглээ (кВт)	(6,376)	-	(6,376)	(5,987)	-	(5,987)	(5,645)	-	(5,645)
Нийт ажилтан			2,494			2,406			1,916
Эрчим хүчний интенсити (кВт/ажилтан)			473.7			573.4			746.2

ХҮЛЭМЖИЙН ХИЙН ЯЛГАРАЛ	2023			2022			2021		
	Оффисууд	Салбарууд	Нийт	Оффисууд	Салбарууд	Нийт	Оффисууд	Салбарууд	Нийт
Хамрах хүрээ 1 (тнCOe)			408,064			373,003			241,767
Бензин			247,074			226,191			145,730
Дизель түлш			160,990			146,812			96,037
Нийт ажилтан			2,494			2,406			1,916
Хамрах хүрээ 1 интенсити			163.62			155.03			126.18
Хамрах хүрээ 2 (тнCOe)			1,159,819			1,310,962			1,331,337
Эрчим хүч	881,302	-	881,302	1,020,463	-	1,020,463	1,040,344	-	1,040,344
Халаалт	278,517	-	278,517	290,499	-	290,499	290,993	-	290,993
Нийт ажилтан			2,494			2,406			1,916
Хамрах хүрээ 2 интенсити			465.04			544.87			694.85
Хамрах хүрээ 3 – бусад (тнCOe)			1,142,789			-			-
Ус	1,342	-	1,342	1,312			638		
Хог хаягдал	-		620		-		-		
Хог хаягдал – дахин боловсруулсан	40.96		40.96	34.19		34.19			-
Цаас	18.62		18.62	22.31		22.31			
Хуванцар	6.51		6.51	7.80		7.80			
Шил	9.06		9.06	10.85		10.85			
A4 цаасны хэрэглээ	8,689	28,448	37,137	7,564	26,320	33,884	6,420	23,558	29,978
Хуруу зай			102		32		25		
Томилонт (нислэг)			43,651		32,885		2,538		

Бусад мэдээлэл

Ажилтнуудад зориулсан сургалт

Тогтвортой хөгжлийн зорилго:



Сургалт	2023	2022	2021
БОНЗ-ын сургалтад хамрагдсан ажилтнуудын тоо (давхардсан)	7,362	3,919	1,154
Нийт сургалтын хүн/цаг	164,738	112,588	95,185

Ажилтнуудад зориулсан тэтгэмж

Тогтвортой хөгжлийн зорилго:



Тэтгэмж	2023	2022	2021
Эрүүл мэнд			
Витаминжуулалтын аянд хамрагдсан ажилтнуудын тоо	1,063	-	-
Оффис дээрх эмчид хандан үзүүлсэн ажилтнуудын тоо	1,275	-	-
Эрүүл мэндийн даатгалд хамрагдсан ажилтнуудын тоо	2,494	1,300	1,593
Тусгай хэрэгцээтэй ажилтнууд			
Ажлын байр дээрх ослын улмаас тэтгэмж авч буй ажилтнуудын тоо	503	-	937
Тэтгэвэрт гарсан ажилтнууд			
Нэмэлт санхүүгийн дэмжлэг авч буй тэтгэвэрт гарсан ажилтнуудын тоо	5	-	5

“Тэрбум Мод” Сан

Тогтвортой хөгжлийн зорилго:



Хамтын ажиллагаа	2023	2022	2021
Санхүүгийн дэмжлэг	868 сая төг.	-	-
Тарьсан мод	290	140	247
Нарс	25	-	-
Гацуур	165	140	247
Буйлс	100	-	-

Харицагчидтай холбоотой тоон мэдээлэл

Банкны харилцагчид, хүйсээр

Тогтвортой хөгжлийн зорилго:



	2023	2022	2021
Банкны нийт харилцагчдын хувь, хүйсээр			
Эмэгтэй	48%	48%	48%
Эрэгтэй	44%	43%	43%
Бусад	8%	8%	9%
Банкны нийт зээлийн бүтээгдэхүүний хүртээмж, хүйсээр			
Эмэгтэй	52%	51%	49%
Эрэгтэй	46%	47%	49%
Бусад	1%	2%	2%
Банкны нийт хадгаламжийн бүтээгдэхүүний хүртээмж, хүйсээр			
Эмэгтэй	56%	56%	56%
Эрэгтэй	44%	44%	44%
Бусад	0%	0%	0%

“БОНЗ-тай холбоотой бодлого, журмууд”

БОНЗ-ын нийгмийн хэсэг нь нийгэм, ажлын байрны янз бүрийн сэдвүүдийг хамардаг. Олон талт, тэгш, хүртээмжтэй байдал (DEI) болон Хүний эрхийг хэрэгжүүлэх нь банкны хамгийн чухал нөөц болох хүний нөөцийг хадгалахад тусалдаг хэмээн банк итгэдэг. Голомт банк нь Жендэр, БОНЗ, ТХЗ, Хүний эрхийн асуудлуудыг холбогдох журам, баримт бичгүүдээр нэгтгэн шийдвэрлэсэн.

Хүний эрх	ТХЗ	БОНЗ	Жендерийн эрх тэгш байдал	
				Мэдээллийн аюулгүй байдал
				Зээлийн үйл ажиллагааны бодлого
				Комплеансийн бодлого
				Авлигагай тэмцэх, мөнгө угаахтай тэмцэх журам
				Шүгэл үлээх (ёс зүй болон бусад)
				Жендерийн тэгш байдлыг хангах бодлого
				Үл ялгаварлах бодлого
				Харилцагчийн гомдол шийдвэрлэх механизм
				Харилцагчийн удирдлагын зохицуулалт-Хувийн банк
				Нөхөн олговрын журам
				Ажлын цаг зохицуулалтын журам
				Боловсролын байгууллага болон оюутан суралчидтай хамтран ажиллах
				Хөдөлмөрийн журам
				Сургалт, хөгжлийн журам
				Физик аюулгүй байдлын стандарт
				Маркетингийн үйл ажиллагааны журам – контент, ивээн тэтгэгч
				Маркетингийн үйл ажиллагааны журам – харилцагчийн судалгаа
				Ажлын байран дээрх ослын журам
				ХАБЭА
				Худалдан авалтын үйл ажиллагааны журам
				Тогтвортой хөгжлийн бодлого

Бүрэн нэгтгэсэн

Шинэчлэлт шаардлагатай

БОНЗ тайлагналын стандартуудын нийцэл НҮББОХ-Банк Санхүүгийн Санаачилга, Хариуцлагатай банкны зарчмууд

Зарчмууд	Үүрэг, амлалт	Бүлэг	Хуудас
Зарчим 1. Нийцэл	Бид Үндэсний болон олон улсын гэрээ хэлэлцээрүүд, үүрэг амлалтуудын хүрээнд өөрийн бизнесийн стратегийг байгаль орчин болон нийгэмд эерэг нөлөө үзүүлэх зарчимтай нийцүүлнэ.	Тогтвортой засаглал	17-19
Зарчим 2. Нөлөөлөл ба зорилтот түвшин	Бид үзүүлж буй бүтээгдэхүүн үйлчилгээ, үйл ажиллагаагаар дамжуулан байгаль орчин ба нийгэмд үзүүлэх сөрөг нөлөөг бууруулах, эерэг нөлөөг бий болгох; мөн байгаль орчин болон нийгмээс үүдэлтэй банканд үзүүлэх боломжтой эрсдэлүүдийг удирдах чадварыг тасралтгүй хэрэгжүүлэх, бэхжүүлэх болно. Үүний хүрээнд, нөлөө ихээр үзүүлж буй байгаль орчин болон нийгмийн асуудлуудын хүрээнд бууруулах зорилго зорилтуудыг тавин ажиллана.	Уур амьсгалын эрсдэл Тогтвортой санхүүжилт	35-37 45-47 21-28
Зарчим 3. Харилцагч, үйлчлүүлэгчид	Бид одоогийн болон ирээдүй хойч үеийнхний тогтвортой хөгжлийг бий болгох, эдийн засгийн ногоон, тогтвортой шилжилтийг эрчимжүүлэхийн тулд харилцагчид, үйлчлүүлэгчидтэйгээ хариуцлагатай хамтын ажиллагааг бэхжүүлнэ.	Тогтвортой санхүүжилт	21-28
Зарчим 4. Оролцогч талууд	Бид зорилго зорилтууддаа хүрэхийн тулд оролцогч талуудтай идэвхтэй, хариуцлагатай зөвлөлдөж, хамтран ажиллах болно.	Олон талт оролцоо	50-51
Зарчим 5. Засаглал ба соёл	Бид тогтвортой засаглал болон хариуцлагатай банкны соёлыг бий болгох замаар өөрийн хүлээсэн үүрэг амлалтаа биелүүлэх болно.	Засаглал	17-19
Зарчим 6. Ил тод байдал ба хариуцлага	Бид зарчмуудын хэрэгжилтийг цаг тухай бүрд нь хянаж, ил тод нээлттэй тайлагнах болно.	Тайлагнал	64

Монголын хөрөнгийн биржийн БОНЗ, тогтвортой байдлын тайлагналын стандарт

Төрөл	Код	Хамаарах ТХЗ	Хамаарах GRI стандарт	Тайлагнах асуудлууд	Тайлбар/Лавлагаа	Эх үүсвэр
Тогтвортой хөгжлийн удирдлагын тогтолцооны үзүүлэлтүүд	MS1		GRI 102-14	Удирдлагын амлалт	Гүйцэтгэх захирлын өмнөх үг, амлалт	6,7
	MS2		GRI 102-14	Тогтвортой хөгжлийн бодлого, зохицуулалт	Стратеги	10,14
	MS3		GRI 102-22	Бүтэц удирдлага	Засаглал болон хороод	16-19
	MS4		GRI 102-15	Нөлөөллийн үнэлгээ	Гол нөлөөлөл, эрсдэл ба боломжууд	22,35
	MS5		GRI 102-16	Чадавх бүрдүүлэлт	Нэг ажилтан/цагт ногдох сургалт, хүйсээр	29
	MS6		GRI 102-31	Хяналт	Аудит	64
	MS7		GRI 102	Тогтвортой байдлын тайлагнал	Хариуцлагатай банкны зарчмууд, E&Y аудит	64
	MS8		GRI 102	Гишүүнчлэл		58
Байгаль орчны үзүүлэлтүүд	E1	ТХЗ-7 & ТХЗ-13	GRI 302	Эрчим хүч		35,54
	E2	ТХЗ-7 & ТХЗ-13	GRI 302	Хүлэмжийн хийн ялгарал		54
	E3	ТХЗ-7 & ТХЗ-13	GRI 201	Уур амьсгалын өөрчлөлт	Зорилтууд, уур амьсгалын өөрчлөлтийн эрсдэл	9
	E4	ТХЗ-6	GRI 303	Ус	Усны хэмнэлт	56
	E5	ТХЗ-12	GRI 306	Хог хаягдал	Хог хаягдлыг дахин боловсруулах хувь	56
	E6	ТХЗ-12 & ТХЗ-15	GRI 304	Биологийн олон янз байдал	Усны зорилт	59

Нийгмийн үзүүлэлтүүд	S1	TX3-XX	GRI 401	Хүний нөөцийн өсөлт хөгжил	Бүтэн цагийн ажилтан, шинэ ажилтнуудын сургалтын дундаж цаг	52-55, 57
	S2	TX3-3	GRI 403	Хөдөлмөрийн аюулгүй байдал, эрүүл ахуй	Урьдчилан сэргийлэх эрүүл мэндийн үзлэгт хамрагдалт	57
	S3	TX3-5	GRI 405	Эрх тэгш байдал	Ажилтнуудын статус тус бүрээр, хүйсээр	52-53
	S4	TX3-10	GRI	Хүртээмжтэй байдал	Хөгжлийн бэрхшээлтэй ажилтнуудын хувь, хүртээмжтэй үйлчилгээ	52
	S5	TX3-11	GRI 413	Олон нийтийн оролцоо, ил тод байдал	Өргөдөл гомдлын бодлого, гомдол шийдвэрлэлтийн хувь	58
	S6	TX3-12	GRI 201, GRI 414	Нийлүүлэлтийн сүлжээний менежмент	Дотоод ханган нийлүүлэгчид, бодлого	36
Засаглалын үзүүлэлтүүд	G1	TX3-16	GRI 201	Авлига болон ёс зүй	ТУЗ-н бүтэц, бусад мэдээллүүд	Хувьцаа эзэмшигчдийн жилийн тайлан
	G2	TX3-16	GRI 417	Компанийн засаглал	Авлигын эсрэг мэдээлэл	Жилийн тайлан
	G3	TX3-16	GRI 201	Комплаенс	Комплаенсын бодлого	Жилийн тайлан
	G4	TX3-16		Оролцогч талын оролцоо		49
Санхүүгийн салбарын нэмэлт үзүүлэлтүүд	FS1	TX3-13		Санхүүгийн мэдлэг дээшлүүлэх, хүртээмжтэй байх санаачилга		42
	FS2	TX3-13		БОНЗ-ын эрсдэлийн шалгуураар үнэлсэн гүйлгээ		45-47
	FS3	TX3-13		Монголын ногоон таксономи ангилалд нийцсэн ногоон зээл		27

БОНЗ-той холбоотой шагнал, үнэлгээ



Жендэрийн Манлай байгууллага 2023



Тогтвортой санхүүжилтийн
Шилдэг банк 2019



Тогтвортой санхүүжилтийн
Манлай банк 2020



Тогтвортой санхүүжилтийн
Шилдэг банк 2021



Тогтвортой санхүүжилтийн
Шилдэг банк 2022

Ил тод нээлттэй тайлагнал

Тайлангууд	Хамаарах жил	Холбоос
Тогтвортой хөгжлийн тайлан	2020	ENG: Sustainable Development (golomtbank.com)
Тогтвортой хөгжлийн тайлан	2021	MON: Тогтвортой хөгжил (golomtbank.com)
Тогтвортой хөгжлийн тайлан	2022	
Хариуцлагатай банкны зарчмууд: Явцын тайлан	2021	ENG: Sustainable Development (golomtbank.com)
Хариуцлагатай банкны зарчмууд: Явцын тайлан (E&Y баталгаажуулсан)	2022	
Хариуцлагатай банкны зарчмууд: Явцын тайлан (E&Y баталгаажуулсан)	2023	2024 оны 8-р сард тайлагнана. Аудитын баталгаажуулалт хийгдэж байна.
Нийгмийн хариуцлага	2023	Жилийн тайлан 2023 (98-103р хуудас)

